



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

ЖИЛИЙН ТАЙЛАН

2021



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

ЖИЛИЙН ТАЙЛАН

2021



2021 оны онцлох үйл явдал.....	4
Санхүүгийн мэдээллийн албаны мэндчилгээ.....	7
Санхүүгийн мэдээллийн алба.....	9
Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц, зохион байгуулалт.....	10

БҮЛЭГ I. МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ12

1.1. Мэдээлэл цуглуулах.....	12
1.2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх.....	14
1.3. Мэдээлэл солилцох.....	16
1.3.1. Дотоодын байгууллагатай мэдээлэл солилцох.....	16
1.3.2. Гадаадын байгууллагатай мэдээлэл солилцох.....	17

БҮЛЭГ II. ДОТООД БА ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА18

2.1. Дотоод хамтын ажиллагаа.....	18
2.1.1. Үндэсний зөвлөл.....	18
2.1.2. Хамтын ажиллагааны зөвлөл.....	22
2.2. Гадаад хамтын ажиллагаа.....	27
2.2.1. Олон улсын хамтын ажиллагаа /ФАТФ, АНДМУТБ, Эгмонт бүлэг/.....	27
2.2.2. Харилцан ойлголцлын санамж бичиг.....	31
2.3. Олон улсын хамтын ажиллагаа.....	33

БҮЛЭГ III. ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ34

БҮЛЭГ IV. ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА40

4.1. Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудад хийсэн сургалт, семинар.....	40
4.2. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын хамрагдсан сургалт, семинар.....	42
4.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа.....	43

БҮЛЭГ V. МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН БҮТЭЦ48

5.1. Санхүүгийн мэдээллийн албаны дотоод мэдээллийн систем.....	48
5.2. goAML программ хангамж.....	49

БҮЛЭГ VI. ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ - ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР50

6.1. Үндэсний эрсдэлийн үнэлгээ.....	50
6.2. Үндэсний хөтөлбөр.....	51

БҮЛЭГ VII. ХЯНАЛТ ШАЛГАЛТ53

ХАВСРАЛТ57

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2018-2021/	15
Зураг 2. Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдсан байдал /2021 он/	27
Зураг 3. Монгол Улсын 2021 оны 4 дэх шатны Явцын тайлан.....	29
Зураг 4. Бусад орны Санхүүгийн мэдээллийн албадтай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн жагсаалт	32
Зураг 5. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооны 2021 оны 7 дугаар сарын 13-ны өдрийн цахим хурал	34
Зураг 6. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээний хуваарилалт	37
Зураг 7. Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2019-2021/	40
Зураг 8. Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас (https://fu.mongolbank.mn)	43
Зураг 9. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдээллийн нэгдсэн систем (www.amlcft.mn)	44
Зураг 10. Санхүүгийн мэдээллийн албаны дотоод мэдээллийн бүтэц	48

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн гүйлгээний тоо /2019-2021/	12
Хүснэгт 2. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн гүйлгээний тоо /салбараар-2021 он/	12
Хүснэгт 3. Гаалийн мэдүүлгийн тоо /2018-2021/	13
Хүснэгт 4. Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2018-2021/	15
Хүснэгт 5. Санхүүгийн мэдээллийн албаны дотоодын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал	16
Хүснэгт 6. Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцсон байдал	17
Хүснэгт 7. Монгол Улсын 2021 оны Явцын тайлангийн үр дүн	35
Хүснэгт 8. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн үнэлгээ	36
Хүснэгт 9. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын сургалт, семинарт хамрагдсан байдал.....	42
Хүснэгт 10. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа.....	55



Монгол Улсыг Европын Холбооны жагсаалтаас гаргав

Монгол Улс 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарсантай холбогдуулан Европын Холбооноос Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалт буюу “Хар жагсаалт”-аас 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр гаргав.




Мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан сэжигтэй гүйлгээний гарын авлагууд гаргав

Санхүүгийн мэдээллийн албанаас 2022 оны 3 дугаар сард банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд зориулсан “Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага” болон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд” гарын авлагыг тус тус гаргаж хүргүүлэв. Мөн гарын авлагуудыг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд байршуулсан.



Санхүүгийн мэдээллийн албаны статистикийн мэдээлэл гаргах журмыг шинэчлэн батлуулав

“Санхүүгийн мэдээллийн албаны статистикийн мэдээлэл гаргах журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А-93 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Тус журмын хавсралтаар баталсан маягтуудад мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрээр статистик мэдээллийг ялгаж, тоон болон чанарын шинж чанараар нь нарийвчлан задалж, тусгахаар болсон. Үүний дүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой олон улсын үнэлгээ, тайлан мэдээнд шаардагдах статистик мэдээллийг нарийвчлан гаргах боломжтой болох юм.



Монгол Улсын 2021 оны Явцын тайлангаар ФАТФ-ын Зөвлөмжийн үнэлгээг ахиуллаа

Монгол Улсын 2021 оны Явцын тайланд Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд авсан арга хэмжээний талаар тайлагнасан. Энэ хүрээнд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2021 оны 7 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын тайланг хэлэлцэж, улмаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлд суурилсан аргачлалын үр дүнг хэрэгжүүлж байгаа гэж дүгнэсэн. Үүний дүнд Зөвлөмж 1-ийн үнэлгээг нэг шатаар ахиулахаар шийдвэрлэж, "Дийлэнхийг биелүүлсэн" үнэлгээтэй болгосон. Зөвлөмж 1-ийн үнэлгээг ахиулснаар ФАТФ-ын 40 Зөвлөмжийн нийт 38 Зөвлөмжийн үнэлгээ "Дийлэнхийг биелүүлсэн" болсон бөгөөд энэхүү ахиц дэвшил нь Санхүүгийн мэдээллийн алба болон Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн холбогдох байгууллагуудын хүчин чармайлт, хамтын ажиллагааны үр дүн байлаа.



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг боловсрууллаа

Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн "Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр" болон түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Санхүүгийн мэдээллийн албанаас олон улсын туршлага болон дотоод хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулав. Энэхүү Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, дараагийн шатны харилцан үнэлгээний үр дүн амжилттай байх, олон улсын байгууллагын хориг жагсаалтад орохгүй байх ач холбогдолтой юм.



Цахим орчинд хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллав

Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан "Мөрийтэй тоглоом зохион байгуулах", 18.6 дугаар зүйлд заасан "Мөнгө угаах" гэмт хэргийг илрүүлэх хүрээнд цахим орчинд хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллалаа.



Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдав

Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад холбогдох эрх бүхий байгууллагууд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл болон дагалдах хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтүүдийг Хууль, тогтоомжийн тухай хууль болон бусад олон улсын туршлага, стандартад нийцүүлэн боловсруулсан. Улмаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганаар батлав. Уг хууль батлагдсанаар Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчин бүрдэж, ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын тогтолцоо бүрдэх, мэдээлэх үүрэгтэй этгээдийг тодорхойлох, салбарын эрсдэлийг үнэлэх, стандарт шаардлагад нийцсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй болох зэрэг ач холбогдолтой юм.



Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан гарын авлагуудыг нийтлэв

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдаж, хууль, эрх зүйн орчин бүрдсэнтэй холбогдуулан "Виртуал хөрөнгийн ерөнхий ойлголт, зах зээл ба зохицуулалтын нөхцөл байдлын гарын авлага"-ыг боловсруулан гаргав. Мөн ФАТФ-ын "Виртуал хөрөнгийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд" болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ФАТФ-ын "Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага"-ыг орчуулан Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд нийтэлсэн.



Мэдээлэл хүлээн авах цахим системийг нэвтрүүлэх ажлыг хийж гүйцэтгэв

Санхүүгийн мэдээллийн албанаас НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргасан goAML программын мэдээлэл хүлээн авах схем болон утгуудыг Монгол Улсын хууль эрх зүйн орчин, мэдээллийн төрөлд нийцүүлэн тохируулж, интерфэйсийг Монгол хэлнээ орчуулах, схемийн танилцуулга, заавар болон дагалдах бусад баримт бичгийг боловсруулан арилжааны банкуудад түгээж, албан ёсоор үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллав.

Санхүүгийн мэдээллийн албаны 15 жилийн ой боллоо

Монгол Улс 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталж, 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Санхүүгийн мэдээллийн албыг байгуулснаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэс, суурийг тавьсан. 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны 15 жилийн ой болж өнгөрлөө.



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ МЭНДЧИЛГЭЭ

Санхүүгийн мэдээллийн албаны 2021 оны үйл ажиллагааны тайланг та бүхэнд танилцуулж байна. 2021 он бол Ковид-19 цар тахлын нөлөөлөл Монгол Улсад төдийгүй дэлхий дахинд хүчтэй нөлөөлсөн, цахим орчныг илүү ашиглан үйл ажиллагаагаа хэвийн үргэлжүүлэх шаардлага тулгарсан, нэлээдгүй сорилттой жил байлаа. Цар тахлын нөлөөгөөр эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа саарч Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн бэлэн мөнгөн гүйлгээний тайлангийн тоо, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн тоонд бууралт гарсан жил болсон. Санхүүгийн мэдээллийн албаны хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо өмнөх онтой харицуулахад 41 хувиар буурсан боловч Санхүүгийн мэдээллийн албанаас хийсэн дүн шинжилгээ болон хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн мэдээллийн тоо өмнөх оныхоос өссөн дүнтэй гарсан байна.

Өнгөрсөн жилд Санхүүгийн мэдээллийн алба нь санхүүгийн мэдээллийг мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах, чанаржуулах чиглэлд төвлөрөн ажиллаж, мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл хүлээж авах дэвшилтэт технологид суурилсан нэгдсэн порталтай болох зорилгоор НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC)-ын боловсруулсан goAML програм хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийг холбох, түрших, энэ чиглэлээр мэдээлэх үүрэгтэй этгээдийн хариуцсан ажилтнуудыг сургах зорилгоор нэлээдгүй ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн цар тахлын үед олон улсын хурал, сургалт, тайлан хамгаалалт, мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн санамж бичиг байгуулах зэргээр гадаад хамтын ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхийг зорьж ажиллалаа.

2021 онд хууль эрх зүйн орчны ФАТФ-ын 40 зөвлөмжтэй нийцтэй байдлыг хангах зорилгоор Монгол Улсад анх удаа виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэхтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болголоо. Түүнээс гадна Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбогдох үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж, ФАТФ-ын Зөвлөмж 1-ийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулав. Мөн Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын хэмжээнд цаашид хийж хэрэгжүүлэх үндэсний бодлого, хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж ажиллалаа.

Цар тахлын үед Санхүүгийн мэдээллийн алба болон бусад гишүүн байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр зайнаас болон газар дээрх сургалт, семинар, уулзалтуудыг тогтмол зохион байгуулж, гадаадын болон дотоодын эрх бүхий байгууллага, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллалаа.

Бид цаашид эрх бүхий байгууллагуудтай хамтран Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлуулах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг үндэсний хэмжээнд чанаржуулж, шууд хэрэгжилтийн үр дүнг сайжруулах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.

Мөн түүнчлэн Санхүүгийн мэдээллийн албаны үндсэн үйл ажиллагаанд шинэ, технологийг нэвтрүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн шинэ хандлага, арга хэлбэрийг илрүүлэх, хууль сахиулах байгууллагад дүн шинжилгээний үр дүнг цаг алдалгүй шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр идэвхийлэн ажиллах болно.

Эцэст нь Санхүүгийн мэдээллийн албатай холбоотой ажилладаг ХАЗ, ҮЗ-ийн гишүүн байгууллагууд, мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд үргэлж бидний ажлыг дэмжин хамтарч ажилладагт талархал илэрхийлж байна.

Санхүүгийн мэдээллийн
албаны дарга **Б.БАТБААТАР**

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

Монгол Улс 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталж, 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Санхүүгийн мэдээллийн албыг байгуулснаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэс, суурийг тавьсан.


Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан, мэдээлэл хүлээн авах, дүн шинжилгээ хийх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилладаг. Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад болон дотоодын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг олон нийтэд таниулах, хяналт тавих зэрэг хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн мэдээллийн алба нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ зүй бус хөндлөнгийн оролцоо, нөлөөллөөс ангид байж, хараат бус ажилладаг, бие даасан байгууллага юм.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын стандарт болох 40 Зөвлөмжийг боловсруулан гаргасан. Дэлхийн улс орнууд эдгээр зөвлөмжийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дагаж мөрддөг. Уг стандартын Зөвлөмж 29-д Санхүүгийн мэдээллийн албаны эрхлэх үйл ажиллагааны стандартыг тодорхойлон тусгасан байдаг бөгөөд манай улсын Санхүүгийн мэдээллийн алба энэ стандарт, шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкны дэргэд байгуулагдсан Санхүүгийн мэдээллийн алба нь олон улсын зарчим, стандартыг хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулж ирсний үр дүнд олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, Эгмонт бүлэгт 2009 онд элсэн орсон. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад улс орны Санхүүгийн мэдээллийн албадуудтай мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

Түүнээс гадна Монгол Улс нь ФАТФ-ын бүс нутаг хариуцсан байгууллага болох Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүнээр 2004 онд элсэн орж, одоог хүртэл ФАТФ-аас гаргасан олон улсын стандартын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо тогтмол үнэлүүлж байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

-  Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;
-  Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий хууль сахиулах болон терроризмтай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;
-  Мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар тогтмол мэдээлэх;
-  Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;
-  Программын тасралтгүй ажиллагааг хангах, сервер, компьютер, техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангах ажлуудыг удирдан зохион байгуулах;
-  Судалгаа шинжилгээ хийх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны статистик мэдээллийг нэгтгэн гаргах.

БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

-  Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах;
-  Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад болон дотоодын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах;
-  Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, мөн эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;
-  Санхүүгийн хориг арга хэмжээний жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;
-  Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан Үндэсний стратеги, хөтөлбөрийг боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;
-  Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;
-  Санхүүгийн мэдээллийн алба болон холбогдох дотоод байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, сургалт зохион байгуулах;
-  Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албыг хариуцах;
-  Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих.

1.1.МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс 20 сая төгрөгөөс дээш дүнтэй Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан болон Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангаас гадна Сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авдаг (Хүснэгт 1,2).

Хүснэгт 1. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн гүйлгээний тоо /2019-2021/

Үзүүлэлт	2019	2020	2021
Бэлэн мөнгөний гүйлгээний тоо	562,926	402,496	336,518
Сэжигтэй гүйлгээний тоо	2,385	3,014	1,801
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо	131,715	143,191	211,176

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн алба 2021 онд мэдээлэх үүрэгтэй этгээдээс нийт 1,801 сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авсан нь өмнөх онтой харьцуулахад 41 хувиар буурсан байх бөгөөд энэ нь Ковид-19 цар тахлын улмаас зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, хөл хорио тогтоосон, мөн 2021 оны эхний 2 улиралд төр, хувийн хэвшлийн байгууллагууд зайнаас ажилласантай холбоотой байна. Харин гадаад төлбөр тооцооны гүйлгээ өмнөх онтой харьцуулахад 32 хувиар өссөн байгаа нь мөн адил Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улсын хил хаагдсанаас болж иргэд, хуулийн этгээдийн гадаад улс руу хийх гадаад төлбөр тооцооны гүйлгээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Бэлэн мөнгөний гүйлгээний тоо жил ирэх тусам буурч байгаа нь санхүүгийн салбарын харилцагчдын төлбөрийн картын бэлэн бус хэрэглээ нэмэгдэж, цахим банкны илүү сонгон төлбөр тооцоог бэлэн бусаар хийх хандлага өсөж байгаатай холбоотой гэж үзэж байна. Үүнийг Монголбанкны Төлбөрийн системийн тайланд бэлэн ба бэлэн бус хэрэглээг гүйлгээний тоогоор авч үзэхэд 2018 оноос бэлэн бус хэрэглээ 3-9%-иар тогтмол нэмэгдэж байгаа, бэлэн хэрэглээ 3-8%-иар тогтмол буурч байгааг харуулсан тоон үзүүлэлтээс харж болно.¹

Хүснэгт 2. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн гүйлгээний тоо /салбараар-2021 он/

Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн гүйлгээний тоо /2021 он/						
	Сэжигтэй гүйлгээний тоо		Бэлэн мөнгөний гүйлгээний тоо		Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо	
	Гүйлгээний тоо	Эзлэх хувь	Гүйлгээний тоо	Эзлэх хувь	Гүйлгээний тоо	Эзлэх хувь
Нийт	1,801	100%	336,518	100%	211,176	100%
1 Банк	1,758	97.6%	317,820	94.4%	201,764	95.5%

¹ Монголбанкны Төлбөрийн системийн тайлан / Төлбөрийн системийн тоон үзүүлэлт, 2021 оны III улирал/

2	Банкнаас бусад санхүүгийн байгууллагууд	23	1.3%	17,836	5.3%	92,22	4.4%
3	Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч	15	0.8%	862	0.3%	190	0.1%
4	Бусад	5	0.3%	-	-	-	-

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн албанд 2021 онд ирүүлсэн бэлэн мөнгөний гүйлгээ, гадаад төлбөр тооцооны гүйлгээ болон сэжигтэй гүйлгээнүүдийн 94-97%-ийг банкуудаас ирүүлэв. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид өөрсдийн салбар дахь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдон үүсэж болох эрсдэл, олон улсын стандартаар тавигдаж буй шаардлага, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдлыг ойлгож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ авч эхэлж байгаатай холбоотойгоор тус салбараас ирүүлж байгаа гүйлгээний тоо өсөх хандлагатай байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгөний гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагаас сар бүр хүлээн авч ажиллаж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Гаалийн мэдүүлгийн тоо /2018-2021/

Үзүүлэлт	2018	2019	2020	2021
Гаалийн мэдүүлгийн тоо	1,413	11,870	5,520	2,660

Эх сурвалж: Монголбанк, СМА

Сүүлийн хоёр жил гаалийн мэдүүлгийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа нь Ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн зорчих хөдөлгөөн, хил, гаалийн хөдөлгөөнийг хязгаарласантай шууд холбоотой байна.

Санхүүгийн мэдээллийн албаны статистикийн мэдээлэл гаргах журам 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Гаалийн ерөнхий газар гаалийн мэдүүлгээс гадна улсын хилээр бэлнээр оруулсан болон гаргасан бэлэн мөнгөний дундаж дүн, улсын хилээр бэлэн мөнгө гаргахдаа үнэн зөв мэдүүлэг гаргахаас зайлсхийсэн, татгалзсан, эсхүл худал мэдүүлсэн зөрчлийн тоо, үнийн дүн, түүнд тавьсан зөрчлийн талаарх мэдээллийг ирүүлдэг болов.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой Харилцан үнэлгээ, Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон бусад тайлан, мэдээнд шаардагдах статистик мэдээллийг нарийвчлан, задаргаатай гаргахад цаг хугацаа шаардаж байсан тул мэдээлэл цуглуулах маягтыг сайжруулах хэрэгцээ үүссэн. Энэ хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Санхүүгийн мэдээллийн албаны статистикийн мэдээлэл гаргах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд шинэ маягтууд нь мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрээр статистик мэдээллийг ялгаж, тоон болон чанарын шинж чанараар нь нарийвчлан задалж, тусгахаар болсон. 2021 оны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой статистик мэдээллийг “Санхүүгийн мэдээллийн албаны статистикийн мэдээлэл гаргах журам”-ын шинэчилсэн маягтуудын дагуу гаргасан болно.

Шигтгээ 1. Санхүүгийн мэдээллийн албаны Үйл ажиллагааны дүн шинжилгээ

Санхүүгийн мэдээллийн алба нь ФАТФ-ын Зөвлөмж 29-т заасны дагуу “Үйл ажиллагааны дүн шинжилгээ” болон “Стратегийн дүн шинжилгээ”-г хийдэг.

Үйл ажиллагааны дүн шинжилгээ нь байгаа болон авч болох мэдээллийг ашиглан тодорхой этгээдүүд (хувь хүн, хөрөнгө, гэмт хэргийн сүлжээ, холбоос)-ийг тодорхойлох, тэдгээрийн явуулж байгаа үйл ажиллагаа, хийж байгаа гүйлгээний түүхийг тодорхойлох, тухайн этгээд болон холбоотой байж болох гэмт хэргийн орлого, мөнгө угаах, холбоотой суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эсэхийг тодорхойлдог.

Үйл ажиллагааны дүн шинжилгээнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны чанар, тоог сайжруулах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас банкуудын төлөөлөлтэй хагас жил бүр болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийн төлөөлөлтэй жил бүр уулзалт зохион байгуулж, эргэх холбоог сайжруулан ажилладаг. Тус уулзалтаар Санхүүгийн мэдээллийн албанаас мэдээлэх үүрэгтэй этгээдэд дараах хүрээнд танилцуулга хийж, санал, дүгнэлтийг хэлэлцдэг. Үүнд:

А. Санхүүгийн мэдээллийн албанаас доорх сэдвийн хүрээнд ерөнхий танилцуулга хийнэ.

- Тайлант хугацаанд Санхүүгийн мэдээллийн алба мэдээлэх үүрэгтэй этгээдээс нийт хэдэн гүйлгээ хүлээн авсан эсэх;
- Ирүүлсэн сэжигтэй гүйлгээний сэжиглэх үндэслэлүүд, дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж байгаа сэжигтэй гүйлгээний талаар;
- Хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн, хаасан, хяналтад авсан сэжигтэй гүйлгээний талаар;
- Санхүүгийн мэдээллийн албанаас хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн сэжигтэй гүйлгээтэй холбоотой хэргийг шийдвэрлэсэн байдал

Б. Санхүүгийн мэдээллийн албанаас тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн тайлантай холбоотой санал, дүгнэлтийг хэлэлцэнэ.


- Тухай мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн бэлэн мөнгөний, гадаад төлбөр тооцооны болон сэжигтэй гүйлгээний тооны өсөлт, бууралт, хууль тогтоомжид заасан хугацаанд ирүүлсэн эсэх, маягтын дагуу ирүүлсэн эсэх гэх мэт чанарын асуудлын талаар;
- Тайлагнасан гүйлгээнүүдийн тоо, чанарыг сайжруулахад анхаарах асуудлын талаар;
- Тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн сэжигтэй гүйлгээний сэжиглэх үндэслэлийн талаар;
- Санхүүгийн мэдээллийн алба болон тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдийн хамтын ажиллагааны талаар

В. Санхүүгийн мэдээллийн албанаас шинээр гаргасан гарын авлага, заавар зөвлөмжийн талаар танилцуулдаг.

1.2.МЭДЭЭЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд 2021 онд дараах байдлаар сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийв (Хүснэгт 4).

Зураг 1. Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2018-2021/



Эх сурвалж: Монголбанк, СМА

Хүснэгт 4. Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2018-2021/

Үзүүлэлт	2019	2020	2021
Сэжигтэй гүйлгээний тоо	2,385	3,014	1,801
Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо	84	509	551

Эх сурвалж: Монголбанк, СМА

Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлэх сэжигтэй гүйлгээний тоо өмнөх онтой харьцуулахад буурсан байгаа ч, ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайланд Санхүүгийн мэдээллийн албанаас хийж байгаа дүн шинжилгээний тоо өмнөх оноос 7.6 хувиар өссөн байна. Энэ нь Санхүүгийн мэдээллийн албанаас сэжигтэй гүйлгээний дүн шинжилгээнд онцгой анхаарч, шинжээчдийг холбогдох сургалт, семинарт тогтмол хамруулж, үр чадвар, чадавхыг бэхжүүлж ажиллаж байгаатай холбоотой.

Шигтгээ 2. Санхүүгийн мэдээллийн албаны Стратегийн дүн шинжилгээ

Санхүүгийн мэдээллийн алба нь ФАТФ-ын Зөвлөмж 29-д заасны дагуу “Үйл ажиллагааны дүн шинжилгээ” болон “Стратегийн дүн шинжилгээ”-г хийдэг.

Санхүүгийн мэдээллийн алба нь “Стратегийн дүн шинжилгээ”-г 2019 оноос эхлэн гаргаж байгаа бөгөөд Санхүүгийн мэдээллийн албанд байгаа болон эрх бүхий байгууллагуудаас цуглуулсан мэдээ, мэдээллийг боловсруулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлох зорилгоор хийж, холбогдох байгууллагуудад танилцуулдаг.

Стратегийн дүн шинжилгээний 2020 оны тайлад дурдсанаар мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тоо нэмэгдсэний зэрэгцээ тодорхой гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой гэж үзсэн сэжигтэй гүйлгээний тоо мөн нэмэгдсэн байна. Тухайлбал:

- “цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа зохион байгуулсан байж болзошгүй”,
- “улсын хилээр хууль бусаар бараа/бэлэн мөнгө нэвтрүүлсэн байж болзошгүй”,
- “тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлдэг байж болзошгүй”,
- “татвараас зайлсхийсэн байж болзошгүй”,
- “зөвшөөрөлгүй санхүүгийн үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй” гэх мэт.

Хэдий ахиц дэвшил гарсан боловч 2020 онд нийт сэжигтэй гүйлгээний 45 орчим хувь нь хэт ерөнхий бөгөөд сэжиглэх үндэслэл тодорхой бус ангиллаар мэдээлэгджээ. Ийм сэжиглэх үндэслэл бүхий гүйлгээнүүдийн хувьд мэдээлэх үүрэгтэй этгээд дотооддоо гүйлгээ, харилцагчийг лавшруулан судалж, сэжиглэх үндэслэлээ бататган аль болох тодорхой болгож мэдээлж байх нь Санхүүгийн мэдээллийн албаны сэжигтэй гүйлгээнд хийх дүн шинжилгээний чанар сайжирч, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм.

1.3.МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

1.3.1.Дотоодын байгууллагатай мэдээлэл солилцох

Дотоод хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэгт зааснаар эрх бүхий байгууллагуудтай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл солилцон хамтран ажиллаж, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2021 онд дараах байдлаар мэдээлэл солилцож ажиллав (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Санхүүгийн мэдээллийн албаны дотоодын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал

Үзүүлэлт	2019	2020	2021
СМА-наас дотоодын хууль сахиулах байгууллагуудад шалгуулахаар шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний тоо	48	505	539
Мэдээлэл авах зорилгоор дотоодын хууль сахиулах байгууллагуудаас СМА-д ирүүлсэн хүсэлт /этгээдийн тоогоор/	2,396	3,336	3,665
Хууль сахиулах байгууллагуудаас СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариу /этгээдийн тоогоор/	2,634	3,310	3,834

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн алба нь дотоодын эрх бүхий байгууллагуудтай холбогдох хуулийн хүрээнд харилцан мэдээлэл солилцдог бөгөөд 2020 оноос эхлэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн санд цахимаар хандах эрх авч гэрээ байгуулсан бөгөөд мэдээлэл солилцон хамтран ажиллах гэрээний хүрээнд иргэн, хуулийн этгээдийн анхан шатны бүртгэлийн лавлагаа, мэдээллийг цахимаар авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зөвхөн төрийн байгууллагаар хязгаарлагдахгүй, мөн хувийн хэвшил, түүний дотор банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоо чухал юм. Иймд цаашид Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондох мэдээлэл солилцоог сайжруулах, мэдээлэл солилцох үйл явцыг хялбарчлах талаар олон улсын туршлагыг судлан ажиллаж байна.

Шигтгээ 3. Дотоод хамтын ажиллагааны хүрээнд цахим орчинд хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллав.

Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокуратурын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан “Мөрийтэй тоглоом зохион байгуулах”, 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийг илрүүлэх хүрээнд цахим орчинд хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллалаа.

Энэ хүрээнд цахим орчинд хууль бусаар мөрийтэй тоглоом зохион байгуулсан вэб сайтын Монгол Улсаас хандах эрхийг хязгаарлах, арилжааны банкны дансыг битүүмжлэх, холбогдогч этгээдүүдийг тогтоох зэрэг арга хэмжээг үе шаттай тасралтгүй зохион байгуулж, хууль сахиулах байгууллагаас мөрдөн шалгах ажиллагааг явууллаа. Тус ажилд арилжааны банкууд идэвхтэйгээр хамтран ажилласан. Үүний үр дүнд Цагдаагийн ерөнхий газрын мэдээлж байгаагаар 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар цахимаар мөрийтэй тоглоом зохион байгуулсан 132 вэб сайтын хандах эрхийг хязгаарлаж, тухайн сайтуудын мөнгө татан төвлөрүүлэх, тараалт хийх зэргээр ашиглаж байсан арилжааны банкууд дахь 132 харилцах дансанд хязгаарлалт тогтоож, 1.5 тэрбум төгрөгийг битүүмжлэн мөрдөн шалгах ажиллагааг явуулав.

1.3.2. Гадаадын байгууллагатай мэдээлэл солилцох

ФАТФ-ын Зөвлөмж 29, Эгмонт бүлгээс гаргасан “Санхүүгийн мэдээллийн албадын үйл ажиллагаа болон мэдээлэл солилцооны удирдамж”, Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тус тус заасны дагуу Санхүүгийн мэдээллийн алба нь Эгмонт бүлэг болон бусад улсын Санхүүгийн мэдээллийн албатай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэдээлэл солилцон хамтран ажилладаг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Эгмонт сүлжээгээр дамжуулан 2021 онд дараах байдлаар мэдээлэл солилцон хамтран ажиллав (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцсон байдал

Үзүүлэлт	2019	2020	2021
СМА-аас гадаадын СМА-д явуулсан хүсэлт /этгээдийн тоогоор/	238	353	140
Гадаадын СМА-д явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариу /этгээдийн тоогоор/	202	247	165
Гадаадын СМА-аас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлт /этгээдийн тоогоор/	133	123	149
Гадаадын СМА-аас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариу /этгээдийн тоогоор/	144	112	129

Эх сурвалж: Монголбанк, СМА

2021 онд Санхүүгийн мэдээллийн албанд 8 улсаас 149 этгээдэд холбогдох мэдээлэл хүссэн хүсэлт ирүүлсэн бөгөөд тайлант хугацаанд 3 улсын нийт 129 этгээдэд холбогдох хүсэлтэд хариулсан. Санхүүгийн мэдээллийн албанаас гадаадын 24 улсын Санхүүгийн мэдээллийн албанд нийт 140 этгээдэд холбогдох мэдээлэл хүссэн хүсэлт явуулж, 23 улсаас 165 этгээдэд холбогдох мэдээлэл, хариуг хүлээн авсан бөгөөд АНУ, Хонг Конг, Япон, Оросын Холбооны Улс, Сингапур, Турк улсууд руу хамгийн их хүсэлтийг хүргүүлжээ.

Санхүүгийн мэдээллийн алба нь Эгмонт сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцохоос гадна гадаад улсуудтай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу мэдээлэл солилцож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр туршлага судлах, сургалт, семинар зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах боломжтой. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь хамтран ажиллах гадаад улсын ижил төрлийн байгууллагын цар хүрээг өргөжүүлэх зорилгоор БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Макао, Бүгд Найрамдах Ардчилсан Зүүн Тимор Улс болон Камбожийн Хаант улсын Санхүүгийн мэдээллийн албатай санамж бичиг байгуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд 2021 оны 11 дүгээр сард Бүгд Найрамдах Ардчилсан Зүүн Тимор Улсын Санхүүгийн мэдээллийн албатай Харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.

2.1. ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

2.1.1. Үндэсний зөвлөл



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн эрх зүйн зохицуулалтыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹ дүгээр зүйлд тусгасан байдаг. Энэ хүрээнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 Зөвлөмжийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах зорилгоор тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн захирамжаар баталсан. Улмаар 2018 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 144 дүгээр захирамжаар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчилсэн.



Үндэсний зөвлөлийн гишүүд

Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагууд:

- Хууль зүй, дотоод хэргийн сайд (Үндэсний зөвлөлийн дарга)
- Тагнуулын ерөнхий газрын дарга (Орлогч дарга)
- Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга (Нарийн бичгийн дарга)
- Улсын ерөнхий прокурорын орлогч
- Авлигатай тэмцэх газрын дэд дарга
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга
- Сангийн дэд сайд
- Гадаад харилцааны дэд сайд
- Монголбанкны дэд ерөнхийлөгч
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга
- Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга
- Гаалийн ерөнхий газрын дэд дарга
- Татварын ерөнхий газрын дэд дарга
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга

Үндэсний зөвлөлийн чиг үүрэг:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22^{1.1}-т заасны дагуу Үндэсний зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба нь Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого, хөтөлбөрийн төслийг боловсруулах;
2. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, түүний биелэлтийг үнэлэх, дараагийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах;
3. Зөвлөлийн даргаар дамжуулан Үндэсний хөтөлбөрийн төслийг эрх бүхий байгууллагад хүргүүлж, батлуулах арга хэмжээг авах;
4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх шийдвэрийг хурлаар хэлэлцэн гаргах;
5. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг зөвлөл жил бүр дүгнэж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;
6. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн хуралдааныг 2021 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр болон 12 дугаар сарын 23-ны өдөр тус тус зохион байгуулсан ба Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1. Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2021-2026 оны Үндэсний хөтөлбөрийн төслийн танилцуулга

Үндэсний зөвлөлийн ажлын алба болох Санхүүгийн мэдээллийн албанаас 2020 оны Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2021-2026 оны Үндэсний хөтөлбөр болон түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, төслийг Хамтын ажиллагааны зөвлөл, Үндэсний зөвлөлийн хурал, Терроризмтой тэмцэх зөвлөлийн 3 дугаар улирлын хуралдаанд тус тус танилцуулж, хэлэлцүүлэв. Улмаар Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагуудад хөтөлбөрийн төслийг албан тоотой хүргүүлэн санал авч тусгаснаас гадна Үндэсний зөвлөл болон холбогдох байгууллагуудын 50 гаруй төлөөллийг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийн дараа Санхүүгийн мэдээллийн албанаас оролцогч байгууллагуудын гаргасан саналыг хөтөлбөрт тусгаж, эцэслэн бэлтгээд байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2021 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Үндэсний хөтөлбөрийг эрх бүхий байгууллагаар батлуулах шаардлагатай болсон. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг нэгтгэн жил бүрийн 5 дугаар сарын 25-ны өдөр багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулахаар болсон тул Үндэсний хөтөлбөрийг хууль тогтоомжид нийцүүлэн батлуулахтай холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

2. “Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилт болон Монгол Улсын 2022 оны Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэх тухай

Цаашид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, Монгол Улсын 2022 оны Явцын тайланг боловсруулж ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэх хүрээнд “ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлын сайжруулах ажлын төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, Үндэсний зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар батлахаар шийдвэрлэв.

Тус төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр баталж, зөвлөлийн гишүүн байгууллагуудад хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгов. Улмаар Үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцсэн бөгөөд Монгол Улсын 2022 оны Явцын тайланг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхээр тогтсон юм.

3. Өршөөл үзүүлэх тухай хуулийн талаар ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт тайлагнах

2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Монгол Улсын 7 дахь удаагийн Өршөөл үзүүлэх тухай хуулийг баталсан. Ардын хувьсгалын 100 жилийн ой болон Коронавируст цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор тус хуулийг баталсан бөгөөд зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн болон бусад шийтгэлээс нэг удаа, ял шийтгэлээс чөлөөлөх, ялын эдлэх хугацааг хасах зэрэг зохицуулалтууд тусгагдсан юм. Тус хуульд зааснаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг эдийн засгийн гэмт хэрэг, зөрчлийг өршөөлд хамруулаагүй нь Монгол Улсын өдийг хүртэл авч хэрэгжүүлсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүчин чармайлт, өндөр түвшний үүрэг амлалтаа бататгаж буйн илрэл байлаа. Энэ нь Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжирч, энэ чиглэлийн ойлголтыг ач холбогдол бүхий түвшинд эзэмшсэний үр дүн юм.

ФАТФ-аас 2014 онд сайн дураар татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх схемийг тайлагнах тухай бодлогын баримт бичгийг боловсруулж улс орнуудад ийм төрлийн тогтолцоог хэрэгжүүлэх үед түүнийг тайлагнахыг шаарддаг. Өршөөл үзүүлэх тухай хууль болон уг тайлагналын шаардлагыг 2021 оны 9 дүгээр сард зохион байгуулсан Үндэсний зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцэж, энэхүү хуулийн агуулга ФАТФ-ын 4 суурь зарчимд нийцтэй тухай тайланг бэлтгэх ажлын хэсэг байгуулах талаар хэлэлцэж, шийдвэрлэсэн.

Тус ажлын хэсэг нь хуралдаж Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс баталсан “Сайн дураар татвар төлөх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх схемийг тайлагнах” баримт бичигт дурдагдсан асуудалд татварын хууль эрх зүйн орчин, зохицуулалтын тухай дэлгэрэнгүй судалж, Үндэсний зөвлөлд танилцуулах тайлангийн төслийг бэлтгэж ажиллав.

4. Виртуал хөрөнгийн салбарын зохицуулалт, цаашдын зорилтууд, салбарын эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажлын хэсэг байгуулах

Монгол Улсын хувьд ФАТФ-ын Зөвлөмж 15-ын шаардлагыг хангах хүрээнд виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх шаардлагатай юм. Иймд Үндэсний зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сард болсон ээлжит хурлаар виртуал хөрөнгийн салбарын эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажлын хэсгийг байгуулах саналыг Санхүүгийн мэдээллийн албанаас танилцуулж, хурлаар үүрэг болгосны дагуу Монгол Улс дахь виртуал хөрөнгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах талаарх танилцуулгыг Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар хамтран боловсруулж, Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж танилцуулсан.

Улмаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар тус салбарын эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах үүрэг бүхий дэд ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцэж, дэмжигдэв. Тус ажлын хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооноос ахалж, нийт 9 байгууллагын 29 төлөөлөл дэд ажлын хэсэгт орж ажиллаж эхэлсэн. Ажлын хэсэг нь тус салбарын эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажлын хүрээнд холбогдох виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдээс үйл ажиллагаа, эрсдэлийн талаар асуулга аваад байна.

Улмаар Эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэснээр зохицуулагч байгууллагууд Монгол Улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах юм.

5. Монгол Улсын 2021 оны Явцын тайлан, цаашид шийдвэрлэх асуудлууд

ФАТФ-т Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох 40 Зөвлөмжийн хэрэгжилтийг жил бүр тайлагнадаг. Энэ хүрээнд Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-ний дагуу шаардлагатай арга хэмжээг авч ажилласны дүнд 2020 онд Зөвлөмж 14, 28, 35-ын үнэлгээг дээшлүүлсэн билээ. Харин 2021 онд Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагууд хамтран тухайн оны Явцын тайланг боловсруулж, ФАТФ-ын бүс нутаг хариуцсан байгууллага болох Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлэн, хүсэлт ирүүлэх тухай бүрт нэмэлт тайлбар, мэдээллийг хүргүүлж ажиллалаа.

Тус тайланд Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэн, эрсдэлд суурилсан аргачлалыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа хэмээн дүгнэжээ. АНДМУТБ-ийн Харилцан үнэлгээний хорооны 2021 оны 7 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар Монгол Улсын Явцын тайланг баталж, Зөвлөмж 1-ийн техник хэрэгжилтийн үнэлгээг 1 шатаар ахиулсан байна. Үүний үр дүнд Монгол Улс ФАТФ-ын 40 Зөвлөмжөөс 38 Зөвлөмжийн шаардлага хангасан үнэлгээтэй боллоо.

Эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой Зөвлөмж 1-ийн үнэлгээг ахиулах хүрээнд Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд болох Терроризмтэй тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар голлох үүрэгтэй оролцсон билээ.

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой Зөвлөмж 14-ийн үнэлгээг ахиулахад Санхүүгийн зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн.

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн хяналт шалгалт, зохицуулалттай холбоотой Зөвлөмж 28-ын хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Санхүүгийн мэдээллийн алба, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын нотариатчдын танхим, Монголын хуульчдын холбоо идэвхтэй хамтран ажилласан.

Харин шийтгэл ногдуулахтай холбоотой Зөвлөмж 35-ын хувьд Хууль зүй, дотоод хэргийн яам, Терроризмтэй тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран ажиллалаа.

2.1.2. Хамтын ажиллагааны зөвлөл

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлд заасны дагуу Хамтын ажиллагааны зөвлөл нь Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг

үүргэтэй ажилладаг. Зөвлөл нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн А-229 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Хамтын ажиллагааны зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн А-110 тоот тушаалаар баталсан ба нийт байгууллагуудын саналаар зөвлөлийг Монголбанкнаас удирдахаар шийдвэрлэв. Шинэчлэгдсэн бүрэлдэхүүн нь дараах байгууллагуудын төлөөллөөс бүрдэж байна.

Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд



**ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**



САНГИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ

- Улсын дээд шүүх
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх
- Улсын ерөнхий прокурорын газар
- Монголбанк
- Санхүүгийн мэдээллийн алба
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Санхүүгийн зохицуулах хороо
- Авлигатай тэмцэх газар
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Сангийн яам
- Гадаад харилцааны яам
- Тагнуулын ерөнхий газар
- Терроризмтой тэмцэх зөвлөл
- Цагдаагийн ерөнхий газар
- Улсын бүртгэлийн ерөнхий газар
- Гаалийн ерөнхий газар
- Татварын ерөнхий газар

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22.3-т заасны дагуу Санхүүгийн мэдээллийн алба нь Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг. Хамтын ажиллагааны зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох зөвлөмж, санал гаргах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг Монгол Улсын хэмжээнд судлах, эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүнг тооцох ажиллагааг тогтмол зохион байгуулах;
- Үндэсний эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар зөвлөмж гаргах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, үр дүнгийн талаар мэдээлэл солилцох;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхтэй танилцаж, мөрдүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний болон Хамтын ажиллагааны зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцтай танилцах, шаардлагатай бол хэрэгжилтийг хангаж ажиллахыг шаардах, гүйцэтгэлийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх, хугацаатай үүрэг даалгавар өгөх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангуулах зэрэг холбогдох арга хэмжээг авах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг олон улсын стандарт, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 Зөвлөмжид нийцүүлэх талаар санал гарган танилцуулах;
- Гишүүн байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон бүс нутаг, олон улсын байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилтай уялдуулахад дэмжлэг үзүүлэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, хувийн хэвшил болон олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх;
- Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц, зохион байгуулалт, төсөв, үйл ажиллагааны зардлын талаар санал гаргах, танилцуулах, шийдвэрлүүлэх;
- Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Ажлын хэсгийн хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй танилцах, хэрэгжүүлэх санал зөвлөмж, хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах;
- Хамтын ажиллагааны зөвлөлийн гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.

Хамтын ажиллагааны зөвлөл нь 2021 онд цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 5 дугаар сарын 13, 7 дугаар сарын 9, 10 дугаар сарын 25-ны өдөр тус тус хуралдаж, дараах тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1. Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний бодлого хөтөлбөрийн төслийн тухай

Санхүүгийн мэдээллийн албанаас Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2021-2026 оны Үндэсний хөтөлбөр болон түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, төслийг 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар танилцуулав. Улмаар Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор хөтөлбөрийн төслийг шинэчлэгдсэн хууль болон холбогдох нийтлэг журам, аргачлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 06 тоот албан бичгээр санал авахаар хөтөлбөрийн төслийг Зөвлөлийн гишүүн байгууллагуудад хүргүүлсэн билээ.

Мөн зөвлөлийн хурлаар Үндэсний бодлого, хөтөлбөрийн төслийн талаар Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүд тухайн байгууллагаас томилогдсон Үндэсний зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангаж ажиллах шийдвэрийг зөвлөлийн дарга гаргав.

2. Монгол Улсын 2021 оны Явцын тайлангаар үнэлгээ ахиулах хүсэлт хүргүүлсэн Зөвлөмж 1, 8, 15-тай холбоотойгоор хийгдэх шаардлагатай ажлууд.

Улс орнууд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хийгдсэн ажлуудын талаарх техник хэрэгжилтийн үнэлгээ ахиулах тайланг явуулдаг. Монгол Улс 3 дахь шатны үнэлгээний тайлангаар ФАТФ-ын 40 Зөвлөмжөөс 1, 8, 15 дугаар Зөвлөмж дээр хэсэгчлэн биелүүлсэн гэх үнэлгээтэй үлдсэн. 2021 оны байдлаар Зөвлөмж 1-ийн үнэлгээг нэг шатаар ахиулж, Зөвлөмж 8, 15-ыг хэвээр үлдээсэн. Зөвлөмж 1-ийн үнэлгээг ахиулах хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба, Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажлын албанаас Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон урьдчилан сэргийлэх журамтай холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэсэн бол Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулах хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлаар батлуулсан юм. Мөн зөвлөлийн хурлаар шийдвэрлэсний дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос Зөвлөмж 15-ын хүрээнд тус салбарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулсан.

Зөвлөмж 8-ын хүрээнд ашгийн бус байгууллагатай холбоотой эрх зүйн зохицуулалт болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

3. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт техник туслалцаа болон сургалтын хэрэгцээний талаарх мэдээллийг хүргүүлэх тухай

Санхүүгийн мэдээллийн алба нь олон улсын донор байгууллагуудтай техник туслалцааны хүрээнд идэвхтэй хамтран ажилладаг билээ. Тухайлбал, Монгол Улсыг Саарал жагсаалтаас гаргах ажлын хүрээнд ФАТФ, Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Ази, Номхон далайн хамтарсан бүлэгтэй идэвхтэй хамтарч ажилласан юм. 2021 онд цаашид Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх

бүлгээс хүсэх техник туслалцаа болон сургалтын талаарх саналыг Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлэхээр тохирсон бөгөөд хэрэгцээтэй техник туслалцааны төсөл, сургалтыг хэрэгжүүлэх талаар судлаад байна.

4. Дотоодын их, дээд сургуулиудтай хамтран мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалтын төв байгуулах тухай

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлөөс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дотоодын их, дээд сургуулиудтай хамтран ажиллахаар болсон. Энэ хүрээнд Хамтын ажиллагааны зөвлөлөөс 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Дотоод хэргийн их сургуультай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав.

Санамж бичгийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй боловсон хүчнийг чадавхжуулах, сургагч багш нарыг бэлтгэх, судалгаа шинжилгээ хийх, сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хүрээнд хамтран ажиллаж байна. Цаашид Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Судалгаа, дүн шинжилгээний ажлын хэсэг болон Дотоод хэргийн их сургуулийн төлөөлүүд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулахаар зорьж ажиллаж байна.

5. Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх ажлын хэсгүүдийг шинэчлэн байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, төлөвлөгөөг зөвлөлийн даргаар батлуулах


Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А-229 тоот тушаалаар баталсан Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журмын 2.5-д зөвлөлийн дэргэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах чиг үүрэгтэй хууль сахиулах, хяналт шалгалт, хууль эрх зүй, судалгаа, дүн шинжилгээний болон бусад асуудал хариуцсан Ажлын хэсэг ажиллах тухай заасан байдаг.

Энэ хүрээнд Хамтын ажиллагааны зөвлөл нь 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар зөвлөлийн дэргэдэх нийт 5 ажлын хэсгийг шинээр байгуулахаар шийдвэрлэж, ажлын хэсгийн ахлагч нарыг зөвлөлийн нийт гишүүдийн олонхын саналаар сонгосон. Шинэчлэн байгуулагдсан ажлын хэсгүүд дараах бүрэлдэхүүнээс бүрдэж байна. Үүнд:

1 Судалгаа дүн шинжилгээний ажлын хэсэг	Бүрэлдэхүүн: 12 байгууллагын 23 төлөөлөл
2 Хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсэг	Бүрэлдэхүүн: 17 байгууллагын 35 төлөөлөл
3 Хууль сахиулах ажлын хэсэг	Бүрэлдэхүүн: 8 байгууллагын 20 төлөөлөл
4 Хяналт шалгалтын ажлын хэсэг	Бүрэлдэхүүн: 11 байгууллагын 22 төлөөлөл
5 Хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг	Бүрэлдэхүүн: 11 байгууллагын 26 төлөөлөл

Улмаар Хамтын ажиллагааны зөвлөлийн 2021 оны 07 дугаар сард зохион байгуулагдсан ээлжит хурлаар эдгээр ажлын хэсгүүдийн зүгээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлын төлөвлөгөөг тус тус танилцуулж, нийт ажлын хэсгүүд Хамтын ажиллагааны зөвлөлийн даргын баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, ажиллаж байна.

Зураг 2. Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдсан байдал /2021 он/



Эх сурвалж: Монголбанк, СМА

2.2. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

2.2.1. Олон улсын хамтын ажиллагаа /ФАТФ, АНДМУТБ, Эгмонт бүлэг/



ФАТФ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, дэлхийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газар хоорондын хараат бус байгууллага юм. ФАТФ-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үүргийн дагуу Монгол Улс тогтмол идэвхтэй хамтран ажиллаж байна.




**Asia/Pacific Group
on Money Laundering**

ФАТФ-ЫН ГИШҮҮН ОРНУУД

ФАТФ-ын төрлийн, бүс нутгийн хэмжээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг нь 1997 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улс 2004 онд гишүүнээр нь элссэн. ФАТФ болон ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагаас гишүүн улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж, харилцан үнэлгээний тайлан гаргадаг.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсаас ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2021 оны 02 дугаар сард хүргүүлсэн. Улмаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Харилцан үнэлгээний хорооны цахим хурлыг 2020 оны 7 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, Монгол Улсын техник хэрэгжилтийн 1 Зөвлөмжийн үнэлгээг ахиулж, 2 Зөвлөмжийн үнэлгээг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу Монгол Улсын 2021 оны 4 дэх шатны Явцын тайланг эцэслэн баталж, 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдөр нийтэлсэн.

Зураг 3. Монгол Улсын 2021 оны 4 дэх шатны Явцын тайлан



Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн албанаас Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс зохион байгуулдаг сургалтад хамрагдах, бусад улс орнуудын тайлантай танилцаж, санал өгөх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой ирүүлсэн санал асуулга бөглөх, сайн туршлага, типологи, бодит жишээг хуваалцах, шаардлагатай бусад мэдээллийг хүргүүлэх байдлаар тогтмол хамтарч ажилласан. Тухайлбал, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2021 оны 5 дугаар сард ирүүлсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн техник туслалцаа, сургалтын хэрэгцээтэй холбоотой асуулгыг Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудын саналыг нэгтгэн хариу хүргүүлсэн болно.

Холбоо: <https://www.fatf-gafi.org/publications/mutualevaluations/documents/fur-mongolia-2021.html>

АЗИ, НОМХОН ДАЛАЙН МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ БҮЛГИЙН ГИШҮҮН ОРНУУД



Монгол Улс 2012 оны 5 дугаар сард Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн ажиглагч улсаар нэгдсэн. Тухайн үеэс хойших хугацаанд Монгол Улс уг байгууллагатай тогтмол хамтран ажиллаж, санхүүгийн дүн шинжилгээ, типологи, сайн туршлага зэрэг асуудлуудын хүрээнд мэдээлэл солилцсон. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 2021 оны 5 дугаар сарын 24-нөөс 6 дугаар сарын 04-ний өдрүүдэд болон 2021 оны 11 дүгээр сарын 11-18-ны өдрүүдэд зохион байгуулсан 34, 35 дахь чуулга уулзалтад оролцов.





ЭГМОНТ БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН ОРНУУД



Дэлхийн 167 орны Санхүүгийн мэдээллийн албадын олон улсын нийгэмлэг болох Эгмонт бүлэгт Монгол Улс 2009 онд гишүүнээр элссэн. Эгмонт бүлэг нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор өөрийн гишүүн улс орны Санхүүгийн мэдээллийн албадын үйл ажиллагаа болон мэдээлэл солилцох чадавхыг бэхжүүлэх, туршлага судлах, техник туслалцаа үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, ФАТФ-ын Зөвлөмж 29-д заасны дагуу Эгмонт бүлгээс баталсан “Санхүүгийн мэдээллийн алба хоорондын мэдээлэл солилцох үндсэн зарчим”-ын хүрээнд Эгмонт бүлгийн гишүүн орнуудын Санхүүгийн мэдээллийн албадтай болон хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан гадаад улсын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажилладаг.

Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Эгмонт бүлэг зэрэг олон улсын байгууллагуудын цахим сургалт семинаруудыг 2021 онд идэвхтэй хамтран зохион байгуулсан. Энэ хүрээнд нийт 25 сургалтад Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон хувийн хэвшлийн давхардсан тоогоор 600 орчим төлөөллийг хамруулав. Мөн соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд нийт 35 сургалтыг дангаар болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Эдгээр сургалтад төр, хувийн хэвшлийн байгууллагын 2,700 гаруй төлөөлөл оролцсон бөгөөд виртуал хөрөнгийн салбарын зохицуулалтын орчин, эцсийн өмчлөгчийг тодорхойлох аргачлал, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа, холбогдох сэжигтэй гүйлгээний шинж чанар, цахим луйврын гүйлгээнээс урьдчилан сэргийлэх, ФАТФ-ын 40 Зөвлөмж, олон улсын туршлага, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зэрэг голлох сэдвийг хамруулсан.

ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Эгмонт бүлэг болон бусад олон улсын байгууллагуудаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, хурал, форум, вэбинарын жагсаалтыг дараах байдлаар харуулав. Үүнд:

I улирал	- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 22 дахь удаагийн Типологийн цахим семинар; - ФАТФ-ын “Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг”-ийн тухай цахим сургалт.
II улирал	- Эгмонт бүлгийн Экофел сургалтын төвтэй хамтран төр, хууль сахиулах байгууллагуудад Санхүүгийн мэдээллийн алба, хяналт шалгалт болон хууль сахиулах байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны тухай сургалт; - ФАТФ-ын “Виртуал хөрөнгө” сэдэвт форум; - Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Санхүүгийн бүс бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалт: ФАТФ-ын олон улсын стандарт ба хэрэгжилт” сэдэвт цахим семинар; - ФАТФ-ын “Эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сэдэвт цахим семинар. - Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Эрсдэлийн үнэлгээ ба санхүүгийн бүс бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид” сэдэвт цахим семинар.
III улирал	- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа” сэдэвт цахим техник семинар; - Олон Улсын Валютын Сангийн виртуал хөрөнгийн салбарын талаарх цахим сургалт; - Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын холбооны “Хориг арга хэмжээний жагсаалтад багтсан этгээдийн үйл ажиллагаатай холбоотой типологийн талаарх ойлголт” сэдэвт цахим сургалт; - ФАТФ-ын “Хүрээлэн буй орчны гэмт хэрэгтэй холбоотой мөнгө угаах үйл ажиллагаа” сэдэвт вэбинар.
IV улирал	- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Дата дүн шинжилгээ” сэдэвт цахим сургалт; - Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой ФАТФ-ын шаардлага хэрэгжилт, сайн туршлага” сэдэвт цахим семинар; - Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Санхүүгийн бүс бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сургалт; - Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой ФАТФ-ын хэрэгжилт” сэдэвт цахим сургалт; - Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 23 дахь удаагийн Типологийн цахим семинар; - Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ ба эрсдэлд суурилсан аргачлал” сэдэвт цахим сургалт.

2.2.2. Харилцан ойлголцлын санамж бичиг

Санхүүгийн мэдээллийн алба нь гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон холбогдох суурь гэмт хэргийн дүн шинжилгээний мэдээллийг солилцох цар хүрээг өргөжүүлэх зорилгоор 2021 онд гурван улстай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ажлыг эхлүүлээ. Бүгд Найрамдах Ардчилсан Зүүн Тимор Улсын Санхүүгийн мэдээллийн алба, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс болох Макаогийн Санхүүгийн мэдээллийн алба, мөн Камбожийн Хаант Улсын Санхүүгийн мэдээллийн албанаас санамж бичиг байгуулах хүсэлт ирүүлсэн. Энэ хүрээнд

Санхүүгийн мэдээллийн албанаас дээрх улс орнуудын Санхүүгийн мэдээллийн албадтай байгуулах санамж бичгийн төсөлд харилцан санал солилцож ажиллав. Улмаар 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Бүгд Найрамдах Ардчилсан Зүүн Тимор Улсын Санхүүгийн мэдээллийн албатай "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон холбогдох суурь гэмт хэргийн санхүүгийн мэдээлэл солилцон хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг" байгууллаа. Үлдсэн хоёр улстай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ажил үргэлжилсээр байна. Санхүүгийн мэдээллийн алба 2021 оны байдлаар нийт 20 улстай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллаж байна (Зураг 4).

Зураг 4. Бусад орны Санхүүгийн мэдээллийн албадтай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн жагсаалт

		
Түрк Улсын Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах алба	БНХАУ-ын Мөнгө угаахтай тэмцэх хяналт, дүн шинжилгээний төв	Афганистан Улсын Санхүүгийн гүйлгээ болон тайлангийн дүн шинжилгээний төв
		
Малайз Улсын Санхүүгийн тагнуулын алба	Украин Улсын Төрийн санхүүгийн хяналт шалгалтын газар	Бангладеш Улсын Санхүүгийн тагнуулын алба
		
Мексик Улсын Санхүүгийн тагнуулын алба	Балба Улсын Санхүүгийн мэдээллийн алба	Словени Улсын Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх алба
		
Япон Улсын Санхүүгийн мэдээллийн төв	Беларусь Улсын Төрийн хяналтын хорооны Санхүүгийн хяналтын газар	Филиппин Улсын Мөнгө угаахтай тэмцэх зөвлөл
		
Шри Ланка Улсын Санхүүгийн тагнуулын алба	Молдова Улсын Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх газар	Казахстан Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналтын хороо
		
Өмнөд Солонгос Улсын Санхүүгийн тагнуулын алба	Киргиз Улсын Төрийн санхүүгийн тагнуулын алба	Бүгд найрамдах ардчилсан Зүүн Тимор Улс
		
ОХУ-ын Санхүүгийн хяналтын алба	Тайванийн Мөнгө угаахтай тэмцэх хэлтэс	

2.3 ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

АНУ-ЫН САНГИЙН ЯАМ

АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны албанаас 2016 оноос хойш Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр техник туслалцаа үзүүлж ирсэн. Энэ хүрээнд АНУ-ын Сангийн Яамны Техник туслалцааны албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас 2021 оны 01 дүгээр сараас 2022 оны 6 дугаар сарын хугацаанд Монгол Улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр үзүүлэх техник туслалцааны ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Тус техник туслалцааны хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцон, үйл ажиллагааны нөхцөл буюу гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд:

1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах;
2. Санхүүгийн мэдээллийн албаны чадавхыг нэмэгдүүлэх;
3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах;
4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажилладаг бусад холбогдох байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх.

Энэ хүрээнд Монгол Улсад АНУ-ын Сангийн яамны зөвлөх 2021 оны 12 дугаар сард хүрэлцэн ирж, техник туслалцааг үргэлжүүлэн хамтран ажиллаж байна. Зөвлөх Монгол Улсад ирснээс хойш ажлын төлөвлөгөөний дагуу Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудад долоо хоног бүр сүүлийн үеийн, сонирхолтой сэдвээр сургалт зохион байгуулан ажиллаж байна.

Түүнчлэн АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны албанаас Монгол Улсын Санхүүгийн мэдээллийн албыг Шри-Ланка болон Нидерланд улсуудын Санхүүгийн мэдээллийн албатай холбон goAML программын техник асуулга болон схемийн тохируулга хийх ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

Азийн хөгжлийн банкнаас Санхүүгийн мэдээллийн албаны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр болон түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах чиглэлээр санал, зөвлөгөө өгч хамтарч ажилласан. Мөн тус байгууллагын зөвлөхтэй хамтран гадаад улс орнуудын сайн туршлагыг судалж, олон улсын жишиг загварын дагуу Үндэсний хөтөлбөрийн төслийг сайжруулсан.

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох 40 зөвлөмжийн хэрэгжилтийн талаар жил бүр Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт тайлагнах үүрэгтэй.

Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран Монгол Улсын 2021 оны Явцын тайланг боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн. Тайланг боловсруулах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанаас ажлын төлөвлөгөө гаргаж, нийт 54 удаа цахим хурал зохион байгуулж ажиллав.

Энэхүү Явцын тайланд “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байсан ФАТФ-ын Зөвлөмж 1, 8, 15-ын үнэлгээг ахиулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ахиц дэвшлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний багаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл, тайлбарыг тухай бүр нийт 5 удаа хүргүүлснээс гадна хамтарсан цахим уулзалтыг зохион байгуулсан.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооны 2021 оны 7 дугаар сарын хуралдаанаар Монгол Улсын 2021 оны Явцын тайланг хэлэлцэн баталж, 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдөр тайланг албан ёсоор цахим хуудаснаа нийтлэв.

Зураг 5. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооны 2021 оны 7 дугаар сарын 13-ны өдрийн цахим хурал



Эх сурвалж: Монголбанк, СМА

Уг тайланд Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр эрсдэлд суурилсан аргачлалыг үр дүнтэй хэрэгжүүлж байна хэмээн дүгнэсэн. Улмаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Зөвлөмж 1-ийн техник хэрэгжилтийн үнэлгээ “Хэсэгчлэн биелүүлсэн” байсныг “Дийлэнхийг биелүүлсэн” болгож ахиулсан. Харин Зөвлөмж 8, 15-ын хувьд хууль, эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай гэж үзэн техник хэрэгжилтийн үнэлгээг хэвээр үлдээв (Хүснэгт 7). Үүнд:

Хүснэгт 7. Монгол Улсын 2021 оны Явцын тайлангийн үр дүн

№	ФАТФ-ын Зөвлөмжийн нэр	Өмнөх үнэлгээ	Шинэчилсэн үнэлгээ	Тайлбар
Үнэлгээг ахиулсан 1 Зөвлөмж				
1	Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Дийлэнхийг биелүүлсэн (LC)	Үнэлгээг нэг шатаар ахиулсан.
Үнэлгээг хэвээр үлдээсэн 2 Зөвлөмж				
8	Ашгийн бус байгууллагууд	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Үнэлгээг хэвээр үлдээсэн.
15	Шинэ технологи	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Үнэлгээг хэвээр үлдээсэн.

Эх сурвалж: Монголбанк, СМА

Зөвлөмж 1-ийн дагуу улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС) эрсдэлийг үнэлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Иймд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж, холбогдох төр болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-31 тоот тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам”-д мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлд суурилан хэрэгжүүлэх хялбаршуулсан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаатай холбоотой орсон нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Үүний дүнд мэдээлэх үүрэгтэй этгээдүүд эрсдэлийн үнэлгээ хийж, бага эрсдэлтэй харилцагчийг хялбаршуулсан байдлаар таньж мэдэх боломжтой болсон.

Зөвлөмж 8-ын хүрэндашгийн бус байгууллагын салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, уг салбартай холбоотой мөрдөн шалгах, яллах үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр авсан холбогдох арга хэмжээний талаар Явцын тайланд тусгасан. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас Хууль зүй, дотоод хэргийн яам болон Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран ашгийн бус байгууллагын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Мөн энэ салбарын хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Холбооны эрх зүйн байдлын тухай хууль болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг батлуулах хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллав. Эдгээр хуулийг батлуулснаар ашгийн бус байгууллагын салбарын хяналт шалгалт, зохицуулалтын тогтолцоо болон хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Зөвлөмж 15 буюу шинэ технологитой холбоотой шаардлагыг хангах хүрээнд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд 2021 оны 6 дугаар сарын

17-ны өдөр УИХ-аар хэлэлцэхийг дэмжсэн. УИХ-ын Байнгын хорооноос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн дагалдах хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг төр, хувийн хэвшлийн 30 гаруй төлөөлөлтэйгээр байгуулсан бөгөөд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл ажлын хэсэгт орж ажиллав. Энэ хүрээнд виртуал хөрөнгийн салбарын талаарх олон улсын туршлага, хууль, эрх зүйн орчинтой холбоотой судалгааг хийж гүйцэтгэсэн. Улмаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлав. Уг хууль батлагдсанаар Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчин бүрдэж, ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын тогтолцоо бий болох, мэдээлэх үүрэгтэй этгээдийг тодорхойлох, стандарт шаардлагад нийцсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй болох зэрэг ач холбогдолтой юм.

Мөн Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах хүрээнд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах болон бусад байгууллагууд хамтран виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэн Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсантай холбогдуулан тус үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу шинэчлэх талаар Санхүүгийн мэдээллийн албанаас Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэв.

Монгол Улсын 2021 оны Явцын тайлангийн үр дүнд ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилт нийт 38 Зөвлөмжийн хувьд дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй болсон. ФАТФ-ын Зөвлөмж тус бүрийн техник хэрэгжилтийн үнэлгээ (Хүснэгт 8) болон үнэлгээний хуваарилалт (Зураг 6) дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 8. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн үнэлгээ


/Бүрэн биелүүлсэн: C-compliant, Дийлэнхийг биелүүлсэн: LC-largely compliant, Хэсэгчлэн биелүүлсэн: PC-partially compliant, Биелүүлээгүй: NC-noncompliant/

Зөвлөмж 1- Эрсдэлээ үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх	Зөвлөмж 2- Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо	Зөвлөмж 3- Мөнгө угаах гэмт хэрэг	Зөвлөмж 4- Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ	Зөвлөмж 5- Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг
LC	LC	LC	LC	LC
Зөвлөмж 6- Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ	Зөвлөмж 7- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ	Зөвлөмж 8- Ашгийн бус байгууллага	Зөвлөмж 9- Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж	Зөвлөмж 10- Харилцагчийг таньж мэдэх
LC	LC	PC	LC	LC
Зөвлөмж 11- Баримт материал хадгалах	Зөвлөмж 12- Улс төрд нөлөө бүхий этгээд	Зөвлөмж 13- Корреспондент банкны үйл ажиллагаа	Зөвлөмж 14- Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ	Зөвлөмж 15- Шинэ технологи
C	LC	LC	C	PC

Зөвлөмж 16- Цахим шилжүүлэг	Зөвлөмж 17- Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх	Зөвлөмж 18- Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани	Зөвлөмж 19- Өндөр эрсдэлтэй улс орнууд	Зөвлөмж 20- Сэжигтэй гүйлгээг мэдээлэх
LC	LC	LC	LC	LC
Зөвлөмж 21- Мэдээллийг задруулах болон нууцлал	Зөвлөмж 22- СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх	Зөвлөмж 23- СББМҮҮ: Бусад арга хэмжээ	Зөвлөмж 24- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал	Зөвлөмж 25- Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч
C	LC	LC	LC	LC
Зөвлөмж 26- Санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалт	Зөвлөмж 27- Хянан шалгагчийн эрх мэдэл	Зөвлөмж 28- СББМҮҮ-ийн зохицуулалт, хяналт шалгалт	Зөвлөмж 29- Санхүүгийн мэдээллийн алба	Зөвлөмж 30- Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг
LC	LC	LC	C	C
Зөвлөмж 31- Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл	Зөвлөмж 32- Бэлэн мөнгө зөөвөрлөгчид	Зөвлөмж 33- Статистик мэдээлэл	Зөвлөмж 34- Зааварчилгаа, эргэх холбоо	Зөвлөмж 35- Шийтгэлийн арга хэмжээ
C	LC	LC	LC	LC
Зөвлөмж 36- Олон улсын арга хэрэгслүүд	Зөвлөмж 37- Эрх зүйн харилцан туслалцаа	Зөвлөмж 38- Эрх зүйн харилцан туслалцаа: хөрөнгө царцаах, хураах	Зөвлөмж 39- Гэмт хэрэгтэн шилжүүлэх	Зөвлөмж 40- Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр
C	C	LC	LC	LC

Эх сурвалж: Монголбанк, СМА

Зураг 6. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн үнэлгээний хуваарилалт



Эх сурвалж: Монголбанк, СМА

Монгол Улсын ФАТФ-ын Техник хэрэгжилт болон Үр дүнтэй байдлын үнэлгээний цаг хугацааны матриц (2007-2021)-ыг Хавсралт 1-ээс харна уу.

Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс ФАТФ-ын 40 Зөвлөмжийн үр дүнтэй хэрэгжилтийг хангаж, үнэлгээг ахиулах зорилгоор “ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулсан. Тус төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр баталж, зөвлөлийн гишүүн байгууллагуудад хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгов. Үндэсний зөвлөлийн 2021 оны 12

дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцсэн бөгөөд Монгол Улсын 2022 оны Явцын тайланг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхээр тогтов.

ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ОН ЦАГИЙН ДАРААЛАЛ

2021

01.06

Санхүүгийн мэдээллийн албанаас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн холбогдох гишүүн байгууллагуудын төлөөлүүдтэй Монгол Улсын 2021 оны Явцын тайлангийн агуулгыг хэлэлцэх цахим хурлыг зохион байгуулсан.

2021

01.15

Хариуцсан байгууллагуудаас Зөвлөмж 1, 8 болон 15-ын хүрээнд боловсруулсан тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас нэгтгэж бэлдсэн бөгөөд тайлангийн эхний төслийг танилцуулж, хэлэлцэх цахим хурлыг хийсэн.

2021

01.21

Явцын тайлангийн төсөлд холбогдох байгууллагуудаас өгсөн саналуудын дагуу тайлангийн төслийг шинэчлэн өөрчилсөн хувилбарыг боловсруулахад оролцсон албан тушаалтнуудад танилцуулах цахим хурлыг Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан.

2021

01.29

Монгол Улсын 2021 оны Явцын тайлангийн төслийг холбогдох байгууллагуудтай хэлэлцэж, эцэслэх хурлыг хийсэн.

2021

02.01

Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын 40 Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудыг багтаасан Монгол Улсын 4 дэх шатны Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн.

2021

02.24

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний багаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Зөвлөмж 1-ийн 1.5, 1.7, 1.9-1.11 зэрэг шалгууруудын хүрээнд нэмэлт тайлбар бэлтгэж хүргүүлсэн.

2021
04.12

Явцын тайлангийн төсөлд үнэлгээний багаас өгсөн урьдчилсан санал, дүгнэлтийн дагуу бүх зөвлөмжүүд дээр шаардлагатай мэдээлэл болон тавьсан асуултуудын хариултыг хариуцсан байгууллагуудаас Санхүүгийн мэдээллийн алба хүлээн авч нэгтгэн, шинэчилсэн хувилбарыг явуулсан.

2021
05.14

Зөвлөмж 15-тай холбоотой зарим асуудлуудыг үнэлгээний багтай хэлэлцэх цахим уулзалтыг Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан бөгөөд холбогдох албан тушаалтнуудыг оролцуулж, үнэлгээний багийн асуусан асуултуудад тайлбар өгсөн.

2021
05.17

Цахим уулзалтын үеэр үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийн дагуу Зөвлөмж 15-ын хүрээнд тайланд холбогдох өөрчлөлт, сайжруулалтуудыг хийж, Санхүүгийн мэдээллийн албанаас Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт шинэчилсэн байдлаар хүргүүлсэн.

2021
06.04

Монгол Улсын 2021 оны Явцын тайланд үнэлгээний багаас өгсөн саналуудыг Санхүүгийн мэдээллийн алба тайланд оруулан эцэслэж, ФАТФ болон ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагуудын гишүүн улс орнуудад хүргүүлэх хувилбарыг бэлэн болгосон.

2021
07.13

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооны ээлжит цахим хурлаар Монгол Улсын 2021 оны 4 дэх шатны Явцын тайланг амжилттай хамгаалсан бөгөөд бусад улс орнуудаас хүлээн зөвшөөрсөн тул Зөвлөмж 1-ийн үнэлгээг ахиулахаар шийдвэрлэсэн. Улмаар ФАТФ-ын 40 Зөвлөмжийн 38 Зөвлөмж нь “Дийлэнхийг биелүүлсэн” болон “Бүрэн биелүүлсэн” үнэлгээтэй болсон.

2021
08.13

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг Монгол Улсын 4 дэх шатны Явцын тайланг албан ёсоор цахим хуудаснаа нийтэлсэн.

2021
09.27

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд “ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г шинэчилсэн байдлаар баталж, холбогдох байгууллагуудыг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, хариуцсан ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх нь өндөр ач холбогдолтой. Энэ хүрээнд 2021 онд Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэхээс гадна гадагш чиглэсэн сургалт, семинаруудыг тогтмол зохион байгуулж, холбогдох гарын авлага, заавар зөвлөмжүүдийг боловсруулан, мэдээлэх үүрэгтэй этгээдэд түгээн ажиллав.

4.1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНААС ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН СУРГАЛТ, СЕМИНАР

Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд нийт 34 сургалтыг дангаар болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бөгөөд эдгээр сургалтад төр болон хувийн хэвшлийн байгууллагын 2,700 гаруй төлөөлөл оролцсон (Зураг 7).

Зураг 7. Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2019-2021/



Үзүүлэлт	2019	2020	2021
Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан сургалт, семинарын тоо	7	4	15
Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан сургалт, семинарт оролцогчдын тоо	444	136	1377
Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинарын тоо	21	20	19
Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинарт оролцогчдын тоо	1081	886	1387

Эх сурвалж: Монголбанк, СМА

Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад холбогдох төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөллүүдийг урьж оролцуулах ажлыг идэвхтэй зохион байгуулж ажиллав. Санхүүгийн мэдээллийн алба болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинараас онцлон дурдвал:

I улирал	- АНУ-ын Сангийн яамтай хамтран Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хорооны ажилтнуудад Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөлд өгөх санал, зөвлөмжийн талаарх сургалт; - Дэлхийн банк, Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний газартай хамтран төр, хувийн хэвшлийн байгууллагуудад виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ болон тус салбарын олон улсын зохицуулалтын сайн туршлагын тухай сургалт; - Чэйналисис компанитай хамтран виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн талаар төр болон хувийн хэвшлийн төлөөллүүдэд сургалт;
II улирал	- Чэйналисис компанитай хамтран банкуудад криптовалютын эрсдэлийн шинжилгээ, зохицуулалтын тухай сургалт; - Эгмонт бүлгийн Экофел сургалтын төвтэй хамтран төр, хууль сахиулах байгууллагуудад Санхүүгийн мэдээллийн алба, хяналт шалгалт болон хууль сахиулах байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны тухай сургалт; - Банкны ажилтнуудад ФАТФ-ийн 40 Зөвлөмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай сургалт; - Банкны ажилтнуудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гүйлгээний хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, дүн шинжилгээ хийх тухай анхан шатны сургалт;
III улирал	- Европын Сэргээн босголт хөгжлийн банкны түнш харилцагч банкуудад Монгол Улс ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарсан туршлагын талаар сургалт; - Пакистан Улсын Санхүүгийн мэдээллийн албанд Монгол Улс ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарсан туршлагын талаар сургалт; - Банкны ажилтнуудад “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, анхаарах асуудлууд” сэдвээр хэлэлцүүлэг; - Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институттэй хамтран нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийг таниулах сургалт; - Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институттэй хамтран мэдээлэх үүрэгтэй этгээдийн комплаенсийн ажилтнуудад зориулсан сургалт; - Банкны ажилтнуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн, аргачлал, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухай сургалт; - Банкны ажилтнуудад гадаадын улс, орны арилжааны банкуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, туршлагын талаар сургалт; - Хуулийн фирмтэй хамтран виртуал хөрөнгө болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны талаар сургалт;
IV улирал	- Банкны ажилтнуудад зориулсан сүүлийн үеийн шинэ техник, технологи ашиглан хийгдэж буй бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотойгоор харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа болон цаашид анхаарах асуудлуудын талаарх сургалт; - Банкны ажилтнуудад “Эцсийн өмчлөгчийг тодорхойлох аргачлал, анхаарах асуудлууд, түүнийг бүртгэх үйл ажиллагаанд тавигдах Монголбанкны шаардлага” сэдэвт хэлэлцүүлэг; - Шри Ланка улсын Санхүүгийн мэдээллийн албанд зориулан Монгол Улсын виртуал хөрөнгийн салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, туршлага хуваалцах сургалт; - Прокуроруудад зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд Санхүүгийн мэдээллийн албаны гүйцэтгэж буй үүргийн талаар сургалт; - Банкны ажилтнуудад цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа, холбогдох сэжигтэй гүйлгээний шинж чанар болон энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сургалт; - Банкны ажилтнуудад цахим шуудан ашиглан хийгдэх луйврын гүйлгээ болон цахим луйврын гүйлгээнээс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээрх олон улсын туршлага, типологийн тухай сургалт; - Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Гэмт хэрэг, терроризм, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт сургалтад Санхүүгийн мэдээллийн албанаас эцсийн өмчлөгчтэй холбоотой асуудлаар хийсэн сургалт.

4.2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН ХАМРАГДСАН СУРГАЛТ, СЕМИНАР

Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд 2021 онд гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэжлийн сургалт, семинарт байнга хамрагдлаа (Хүснэгт 9). Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын 2021 онд хамрагдсан сургалт, семинарын хувьд дийлэнх нь ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар, Эгмонт бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Олон Улсын Валютын сан, Дэлхийн банк, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Европын холбоо, Япон улсын Санхүүгийн үйлчилгээ газар гэх зэрэг олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан цахим сургалт, семинарууд байв. Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн албанаас АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хөтөлбөрөөр дамжуулан ажилтнуудын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэгээ дээшлүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна.

Хүснэгт 9. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын сургалт, семинарт хамрагдсан байдал

	2019	2020	2021
Ажилтнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамрагдсан сургалт, семинарын тоо	23	33	36

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн албанаас goAML программыг нэвтрүүлж байгаатай холбоотойгоор Үйл ажиллагааны хэлтсийн бүх ажилтнууд 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 2021 оны 10 дугаар сарын 7-ны өдрийг хүртэл НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын goAML программтай холбоотой сургалтад долоо хоног бүрийн 2 өдөр хамрагдаж, программтай холбоотой техник, үр чадвараа сайжруулав.

Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын 2021 онд хамрагдсан сургалт, семинараас онцлон дурдвал:


- Олон Улсын комплаенсын холбооноос зохион байгуулсан “Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг” болон “Харилцагчиг таньж мэдэх нь” сэдвээр 4 өдрийн цахим семинар;
- АНУ-ын Сангийн яамны зөвлөхүүдээс зохион байгуулсан “Виртуал хөрөнгийн тухай болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж 15-ын ойлголтын тухай” сэдвээр цахим сургалт;
- “Чэйналисис” компанийн “Крипто валютын эрсдэлийн шинжилгээ” сэдэвт цахим сургалт;
- НҮБ-ын Терроризмтой тэмцэх албанаас Европын Холбоо болон Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран зохион байгуулсан ФАТФ-ын Зөвлөмж 8 буюу Ашгийн бус байгууллагатай холбоотой цахим сургалт;
- Дэлхийн банк болон Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний газраас зохион байгуулсан виртуал хөрөнгөтэй холбоотой цахим семинар;
- ФАТФ-ын “Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг” сэдэвт цахим сургалт;
- Эгмонт бүлгийн “Санхүүгийн мэдээллийн алба, хяналт шалгалт болон хууль сахиулах байгууллагуудын хоорондох хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо” сэдэвт цахим семинар;

- Европын Холбооны “Виртуал хөрөнгө ба криптовалют” сэдэвт цахим сургалт;
- Дэлхийн банкны зөвлөхүүдтэй хамтран хийсэн виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хэрхэн хийж гүйцэтгэх талаарх цахим сургалт;
- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс зохион байгуулсан “Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сэдвээр цахим сургалт;
- Олон Улсын Валютын Сангийн виртуал хөрөнгийн салбарын талаарх 4 өдрийн цахим сургалт;
- Байгалийн баялагтай холбоотой авлигын гэмт хэрэгтэй тэмцэх консорциумын “Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигатай тэмцэх боломж, байгалийн баялагт үзүүлэх үр нөлөө” сэдэвт цахим сургалтуудад тус тус хамрагдлаа.

4.3. СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн соён гэгээрүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх баримт бичгүүдийг боловсруулж, өөрсдийн цахим хуудсаар (Зураг 8) дамжуулан мэдээлэх үүрэгтэй этгээд болон олон нийтэд түгээв.

Зураг 8. Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас (<https://fiu.mongolbank.mn>)



Эх сурвалж: Монголбанк, СМА

Түүнчлэн Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нэгдсэн мэдээллийн систем болох www.amlcft.mn цахим хуудсыг шинэчилсэн бөгөөд түүгээр дамжуулан Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл, баримт бичгүүдийг байршуулан ажиллалаа. Энэ цахим хуудсаар дамжуулан мэдээлэх үүрэгтэй этгээдүүд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтыг харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд тогтмол ашигладаг.

Зураг 9. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдээллийн нэгдсэн систем (www.amlcft.mn)



Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн албанаас **2021** онд соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд дараах баримт бичгүүдийг боловсруулан, холбогдох байгууллагуудад түгээн, <https://fiu.mongolbank.mn> цахим хуудсанд байршуулав. Үүнд:



1. Санхүүгийн мэдээллийн албаны 2020 оны жилийн тайлан

Санхүүгийн мэдээллийн албаны 2020 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэн гаргалаа. Тус тайланд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлуудыг дэлгэрэнгүй танилцуулсан бөгөөд тайланд 2018-2020 оны статистик, мэдээллүүдийг ашиглав. Энэ жилийн тайлангийн онцлог нь Монгол Улс ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-д орсон болон түүнээс гарахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар он цагийн дараалалтай, дэлгэрэнгүй тусгасан. Жилийн тайланг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудасны хэвлэл нийтлэл хэсэгт байршуулсан бөгөөд хэвлэмэл хувийг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.



2. Стратегийн дүн шинжилгээний 2020 оны тайлан

ФАТФ-ын Зөвлөмж 29-ийн дагуу Санхүүгийн мэдээллийн албаны гаргадаг чухал бичиг баримтуудын нэг бол Стратегийн дүн шинжилгээний тайлан юм. Тус тайланг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллага болон мэдээлэх үүрэгтэй этгээдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох аюул заналхийлэл, сул талыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, нөөц бололцоогоо зөв зохистой хуваарилах, эрсдэл өндөртэй хэсэгт анхаарал хандуулан үйл ажиллагаагаа үр дүнтэй зохион байгуулахад нь мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлэх зорилгоор албан хэрэгцээнд зориулан гаргадаг. Энэ тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас хууль сахиулах байгууллагууд болон мэдээлэх үүрэгтэй этгээдүүдтэй эргэх холбоог сайжруулах чиглэлээр хийсэн уулзалтуудаар танилцуулсан болно.



3. Банк бус санхүүгийн байгууллага, Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, Үнэт цаасны зах зээлд оролцогч, Хадгаламж зээлийн хоршоо, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд зориулсан “Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага”

Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн сэжигтэй гүйлгээ тайлагнах тоо, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр “Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага”-ыг гаргаж, цахим хуудсанд байршуулав. Тус гарын авлага нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхэд хууль, журмаар тавигдах шаардлагуудын талаар мэдээлэл өгөхөөс гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой ерөнхий мэдээлэл, мэдлэг олгохыг зорьсон. Гарын авлагын агуулгын хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг танилцуулж, сэжигтэй гүйлгээ гэж ямар гүйлгээг тодорхойлох талаар, сэжигтэй гүйлгээний нэмэлт мэдээллүүд, мэдээллийн нууцлалыг хамгаалах талаар, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан болно.



4. Банк бус санхүүгийн байгууллага, Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, Үнэт цаасны зах зээлд оролцогч, Хадгаламж зээлийн хоршоо, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд зориулсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийн талаарх гарын авлага”

Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд мэдээлэх үүрэгтэй этгээдийн салбар бүрийн гүйлгээний онцлог, шинж чанарт тохируулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний жишээ, шинж тэмдгүүдийг нэгтгэн, боловсрууллаа. Тус гарын авлагыг мэдээлэх үүрэгтэй этгээдүүд “Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага”-тай хамт үйл ажиллагаандаа ашигласнаар сэжигтэй гүйлгээг таних, илрүүлэх, тайлагнахад өндөр ач холбогдолтой. Тус гарын авлагад дурдсан сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийн жагсаалтыг зөвхөн жишээ, мэдээлэл болгон танилцуулсан бөгөөд сэжигтэй гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогын шинж тэмдгүүд гарын авлагад дурдсан жишээгээр хязгаарлагдахгүй болно.



5. ФАТФ-ын гаргасан “Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага”-ын орчуулга

Монгол Улсад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль, эрх зүйн орчныг бий болгох ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ФАТФ-ын 2021 оны 10 дугаар сард гаргасан “Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид зориулсан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага”-ыг ФАТФ-ын зөвшөөрөлтэйгөөр орчуулан, Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд байршууллаа. Тус гарын авлага нь виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой ФАТФ-ын стандартын цар хүрээ, тус стандартуудыг улс орнууд болон эрх бүхий байгууллага хэрхэн хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлсэн олон улсын жишээ, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хянан шалгагч нарын мэдээлэл солилцох, хамтран ажиллах зарчим зэргийг дэлгэрэнгүй тусгасан.



6. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан “Виртуал хөрөнгийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд”

Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын 2020 оны 9 дүгээр сард гаргасан “Виртуал хөрөнгийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд”-ийн гарын авлагыг орчуулан, Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд байршууллаа. Тус гарын авлага нь виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй шинж тэмдгүүдийг гүйлгээ, гүйлгээ хийж буй хэлбэр, нэрийн нууцлал, шилжүүлэгч, хүлээн авагч, хөрөнгийн эх үүсвэр болон газар зүйн байршилтай холбоотой гэх мэтээр ангилан, холбогдох жишээ кейсүүдээр баяжуулсан гарын авлага болно.




7. Виртуал хөрөнгийн ерөнхий ойлголт, зах зээл ба зохицуулалтын нөхцөл байдлын гарын авлага

Монгол Улсад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхээр холбогдох ажлын хэсгээс хамтран ажилласан. Хуулийн төслийг хэлэлцэхтэй холбоотойгоор ажлын хэсгээс виртуал хөрөнгийн тухай ерөнхий ойлголтыг тусгасан танилцуулга, гарын авлага авах хүсэлтийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 оны 11 дүгээр сард виртуал хөрөнгийн ерөнхий ойлголт, зах зээл ба зохицуулалтын нөхцөл байдлын талаар товч тусгасан гарын авлагыг боловсруулав. Тус гарын авлага нь нийт 7 бүлэгтэй бөгөөд Монгол Улсын виртуал хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал болон олон улсын тухайн үеийн зах зээлийн талаар товч тусгасан болно.

5.1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДОТООД МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс хуульд заасан тайлан мэдээг хүлээн авч, түүнд дүн шинжилгээ хийн, шаардлагатай тохиолдолд хууль сахиулах байгууллагуудад хүргүүлэх арга хэмжээг авдаг. Хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн эрсдэлийг матрицын аргаар үнэлсний үндсэн дээр дүн шинжилгээ хийх үйл явц эхэлнэ. Дүн шинжилгээний үе шатанд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон холбогдох суурь гэмт хэргийн шинжтэй байгаа эсэхийг үр дүнтэй илрүүлэхийн тулд мэдээлэх үүрэгтэй этгээдүүд, эрх бүхий байгууллагуудаас нэмэлт лавлагаа, мэдээлэл гаргуулан авах шаардлага гардаг. Санхүүгийн мэдээллийн албаны энэхүү мэдээллийг хүлээн авах, түүнд дүн шинжилгээ хийх, нэмэлт мэдээлэл авах мэдээллийн урсгалын хурдыг нэмэгдүүлж, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг сайжруулах зорилгоор goAML програм хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна. Санхүүгийн мэдээллийн албаны дотоод мэдээллийн системийн урсгалыг Зураг 10-д харуулав.

Зураг 10. Санхүүгийн мэдээллийн албаны дотоод мэдээллийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк, СМА

5.2. goAML ПРОГРАММ ХАНГАМЖ

Санхүүгийн мэдээллийн албанаас хуульд заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан мэдээлэл хүлээн авах, түүнд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд шаардлагатай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор goAML программыг 2019 оны 12 дугаар сараас үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь 2020-2021 онуудад goAML программыг ашиглалтад оруулж, нэвтрүүлэхэд анхааран ажиллаж, goAML программын схемийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тохируулах, банкуудаас хуульд заасан 3 төрлийн тайлан мэдээллийг тус программаар дамжуулан илгээх, хүлээн авах үйл ажиллагааг турших, заавар зөвлөгөө өгөх, шаардлагатай гарын авлага боловсруулж хүргүүлэх, илгээсэн гүйлгээ тус бүрийг нэг бүрчлэн шалгаж илэрсэн алдааг цаг тухай бүрт нь мэдэгдэж залруулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

- 2021 оны 1 болон 2 дугаар улиралд мэдээлэх үүрэгтэй этгээд болон хэрэглэгчдэд зориулан goAML программыг ашиглах гарын авлагыг орчуулан мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд хүргүүлэв.
- 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн goAML программын тайлан хүлээн авах порталын туршилтыг банкуудтай хийж эхэлсэн. Түүнчлэн сэжигтэй гүйлгээний тайланд нэмэлт мэдээлэл хүссэн загвар файлыг үүсгэж, холбогдох саналуудыг тусган туршилтыг амжилттай гүйцэтгэв.
- Цаашлаад 2021 оны 3 дугаар улиралд 2 удаа банкуудын холбогдох ажилтнуудтай цахим уулзалт хийж, программ ашиглалт, гарч буй алдаа, түүнийг залруулах чиглэлээр хэлэлцүүлэг хийв.
- Мэдээлэх үүрэгтэй этгээдээс гадна албаны шинжээч нарыг сурган дадлагажуулах, программын ашиглалт, тайлан мэдээлэл хүргүүлэх үед гарсан алдаа дутагдлыг арилгах ажлуудыг 2021 оны турш хийж гүйцэтгэв.

Улмаар бүх банкууд урьдчилсан байдлаар goAML программ хангамжийг нэвтрүүлж, туршилтын хугацаанд тайлан мэдээллийг одоо ашиглаж байгаа мэдээллийн сангийн программ болон goAML программаар давхар илгээж байна. Цаашид Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс 2022 онд банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийг goAML порталд холбох, албан ёсоор бүх мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан хүлээж авах үйл ажиллагааг эхлүүлэхээр зорин ажиллаж байна.

**6.1. ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд ФАТФ-ын Зөвлөмж 1-д заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийж, уг үнэлгээний үр дүнд суурилан Үндэсний хөтөлбөрийг боловсруулахаар заасан. Энэ хүрээнд 2016 онд анхны Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулж гаргаж байв.

Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу Дээрх дэд ажлын хэсгүүдэд төрийн байгууллагууд болон холбогдох бүхий л салбарын хувийн хэвшлийн нийт 52 байгууллагын 128 төлөөлөгчид орж ажилласан бөгөөд, эрсдэлийн үнэлгээнд суурилсан эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг 2020 оны 01 дүгээр сараас хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд Сангийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх үндсэн ажлын хэсгийг байгуулснаас гадна Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар зохицуулалттай салбар тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх 10 модулийн 11 дэд ажлын хэсгийг байгуулж ажиллав.

Дээрх дэд ажлын хэсгүүдэд төрийн байгууллагууд болон холбогдох бүхий л салбарын хувийн хэвшлийн нийт 52 байгууллагын 128 төлөөлөгчид орж ажилласан. Дэд ажлын хэсгүүд нь дараах салбаруудын эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Модуль 1.** Мөнгө угаах аюул заналхийллийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 2.** Үндэсний эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 3.** Банкны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 4.** Үнэт цаасны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 5.** Даатгалын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 6.** Банк бус санхүүгийн байгууллагын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 7.** Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 8.** Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 9.** Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 10.** Ашгийн бус байгууллагын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 11.** Виртуал хөрөнгийн салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг

Санхүүгийн мэдээллийн албанаас Дэд ажлын хэсгүүдийн 250 төлөөллийг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулсан ба хэлэлцүүлгийн үеэр дэвшүүлсэн оновчтой санал, зөвлөмжүүдийг дэд ажлын хэсгүүд өөрсдийн модулийн тайландаа тусган боловсруулж Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн.

Эцэслэн боловсруулсан Эрсдэлийн үнэлгээний тайлангийн төслийг эцэслэх хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас Дэлхийн банкны зөвлөхүүдтэй 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдөр цахим уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар эрсдэлийн үнэлгээний тайлантай холбоотой тулгамдаж буй асуудлууд болон эрсдэлийн үнэлгээний үр дүнгийн талаар хэлэлцсэн ба Дэлхийн банкны зөвлөхүүдээс мөн санал зөвлөмж авч, холбогдох өөрчлөлтүүдийг тайланд тусгаж ажиллав.

Улмаар Монгол Улсын 2 дахь удаагийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнг үнэлж дүгнэн “Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дүнд хугацааны Үндэсний хөтөлбөр”-ийг Санхүүгийн мэдээллийн алба боловсруулсан юм. Уг хөтөлбөрт Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, ФАТФ-ын техникийн хэрэгжилт болон үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх асуудлуудыг дэлгэрэнгүй тусгах бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлж ажиллах болно.

6.2. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан 40 Зөвлөмжийн Зөвлөмж 1-т улс орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ үнэлэх, Зөвлөмж 2-т эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг. Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулж батлуулахаар заасан.

Үүнтэй холбоотойгоор 2017 онд Монгол Улсын Засгийн газар 10 зорилтоос бүрдсэн “Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний бодлого хөтөлбөр” баталсан ба хариуцсан байгууллагууд хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн. Харин 2022 онд дараагийн “Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2022-2026 оны Үндэсний бодлого, хөтөлбөр” болон түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай болсон.

Энэ хүрээнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг 2020-2021 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд төр, хувийн хэвшлийн 52 байгууллагын 128 төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг Сангийн сайдын тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс банк, үнэт цаас, даатгал, санхүүгийн бүс бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид зэрэг зохицуулалттай салбар тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлсэн. Улмаар Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын 40 Зөвлөмж болон Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн “Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр” болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох нийтлэг журам, аргачлалын дагуу боловсруулав. Мөн хөтөлбөрийн төслийг боловсруулах чиглэлээр Дэлхийн банкны төслийн хүрээнд олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, олон улсын жишигт нийцүүлсэн.

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр” нь нийт 8 зорилго, 50 гаруй зорилт, 232 үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс бүрдсэн бөгөөд олон улсын стандартын шаардлагыг хангах, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж сайжруулах арга хэмжээг багтаасан. Уг хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 онд Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон Терроризмтой тэмцэх зөвлөлийн хуралдаанд нийт 6 удаа танилцуулан хэлэлцүүлснээс гадна албан бичгээр санал авч, нэг өдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газраар батлуулах байсныг өөрчилж, УИХ-аар батлуулахаар болсон. Иймд Санхүүгийн мэдээллийн албанаас хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам” болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлал”-ын дагуу Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэж байна.

Энэхүү Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм.



БҮЛЭГ VII | ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь тус хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх чиг үүрэгтэй. Мөн тус хуулийн 19.1-д заасны дагуу Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын танхим, Монголын Мэргэшсэн нягтлан бодогчийн институт, Санхүүгийн мэдээллийн алба нь санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй.

Хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр 2020 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1, Зөрчил шалгах шийдвэрлэх тухай хуулийн 6.31 дүгээр заалтад өөрчлөлт оруулснаар Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч, улсын байцаагч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Үй олноор зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай хуулийн зөрчилд арга хэмжээ авах эрх зүйн орчин бүрдсэн. Хуульд өөрчлөлт оруулсантай холбогдуулан хянан шалгагчдын мэдлэг, чадавхыг дээшлүүлэх сургалтад хамруулах, хяналт шалгалтад ашиглах аргачлал, заавар, асуулга, зайны эрсдэлийн үнэлгээний хэрэгсэл зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилласан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас хяналт шалгалтын зохицуулагч байгууллагууд болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоодтой тогтмол хамтран ажиллав. Тухайлбал, 2021 онд мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих чиглэлээр мэргэжлийн холбоод болох Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын танхим, Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллав.

1. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт шалгалт хийх олон улсын туршлагыг судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх талаарх санал, дүгнэлт боловсруулах:

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт шалгалт хийх олон улсын туршлагыг судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх санал дүгнэлтийг боловсруулсны үндсэн дээр санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журмын төслийг боловсруулан Монголбанкны Хууль, эрх зүйн газраас журмын төсөлд санал авсан. Энэ хүрээнд 1) Хяналт шалгалтын асуулга, 2) Эрсдэлийн үнэлгээний асуулга, 3) Хяналт шалгалтын процедур гэсэн материалуудыг бэлтгэж, холбогдох санал дүгнэлтийг боловсруулсан.

2. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалт хийхэд зориулан гарын авлага боловсруулж, мэргэжлийн холбоодод хүргүүлэх:

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ)-д мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалт хийх гарын авлагыг боловсруулсан бөгөөд удирдлагуудаар хянуулж, холбогдох байгууллагуудаас авсан саналд үндэслэн хяналт шалгалтын ажиллагааг журамлах зорилготой арга хэмжээг авч ажиллав. ОУВС болон АНУ-ын СМА-наас зөвлөсний дагуу СББМҮҮ-д зориулсан хяналт шалгалтын баримт материалыг салбар тус бүрээр судалж гарын авлага боловсруулсан. Гарын авлага, заавар зөвлөмж, газар дээр хяналт шалгалтад бэлдэх баримт материалын жагсаалт, хяналт шалгалтын асуулга, мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан үүргийн биелэлтэд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой материалуудыг боловсруулан ажиллав.

3. Санхүүгийн мэдээллийн албанаас санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийх хяналт шалгалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулах дотоод журам боловсруулах:

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд Санхүүгийн мэдээллийн улсын байцаагч шалгалт хийх талаарх дотоод журмын төслийг боловсруулсан бөгөөд хянуулж, санал авсны үндсэн дээр журмын төслийг боловсруулж эцэслэлээ.

4. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэжлийн холбоодын хийж буй хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хамтран хийж гүйцэтгэх:

СББМҮҮ-д МУТСТ чиглэлээр мэргэжлийн холбоодын хийж буй хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажилласан бөгөөд 2021 оны улирал бүрийн хяналт шалгалтын статистик мэдээллийг хамтран гаргасан. Түүнчлэн Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран 5 компанид газар дээрх хяналт шалгалт хийсэн. Мэргэжлийн холбоодод зориулсан хяналт шалгалтын журмын төсөл, хяналт шалгалтын гарын авлагыг боловсруулах хүрээнд журмын төслийг боловсруулан ажиллав.

5. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

Мэргэжлийн холбоодод зориулан санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт шалгалт хийх гарын авлагыг боловсруулсан. Мөн зохицуулагч байгууллагуудын хянан шалгагчдыг эрсдэлд суурилсан хяналт шалгалт, хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны талаарх олон улсын байгууллагуудын цахим сургалт, семинарт хамруулснаас гадна мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийг таниулах, эрсдэлийг ойлгуулах сургалтуудыг зохион байгууллаа.

Санхүүгийн мэдээллийн алба нь хяналт шалгалтын зохицуулагч байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын талаарх нэгдсэн статистик мэдээллийг гаргадаг. Дараах хүснэгтэд нийт мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт болон авсан арга хэмжээний талаар харуулав (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа

Үзүүлэлт	2019	2020	2021
Банканд хийсэн хяналт шалгалт	24	19	17
Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт	269	146	5897
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан актын тоо	-	1	39
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгавар	245	444	269

Эх сурвалж: Монголбанк, СМА

Шигтгээ 4. Олон улсын корреспондент банкны харилцааны нөхцөл байдал, түүний ач холбогдол

ФАТФ-ын Зөвлөмж 13-т санхүүгийн байгууллагын хил дамнасан корреспондент банкны харилцааг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагуудыг тусгасан байдаг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас корреспондент банкны харилцааны нөхцөл байдал, чиг хандлагын талаар олон улсын байгууллагуудаас гаргасан судалгааг танилцуулж байна.

Корреспондент банкны харилцаагаар дамжуулан банкууд өөр улс орнуудын санхүүгийн үйлчилгээнд нэвтэрч, харилцагчдадаа хил дамнасан төлбөрийн үйлчилгээг үзүүлж, олон улсын худалдаа, санхүүгийн хүртээмжийг дэмжих боломж олгодог чухал ач холбогдолтой юм. Харин 2008 оны санхүүгийн хямралаас хойш дэлхий дахинаа корреспондент банкны харилцаа буурч, эрсдэлээс зайлсхийх зорилгоор хязгаарласан тохиолдол ихээр ажиглагдах болсон. Ялангуяа эдгээр үйлчилгээг үзүүлж буй зарим банкууд тогтоосон харилцааныхаа тоог цөөлж, шинээр цөөн хэдэн харилцаа тогтоох болсон байна (BIS, 2016).

Өнөөгийн олон улсын корреспондент банкны харилцаанд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл бол эрсдэлээс зайлсхийх арга хэмжээ юм. Эрсдэлээс зайлсхийх гэдэг нь санхүүгийн байгууллагууд эрсдэлийг удирдах бус харин түүнээс зайлсхийхийн тулд өндөр эрсдэлтэй гэж тооцогдсон харилцагчтай бизнесийн харилцаагаа таслах, хязгаарлах арга хэмжээг хэлнэ (US Department of State). Ашиг багатай, бизнесийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтайгаас гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хяналт шалгалт нэмэгдэж байгаагаас үүдэн эрсдэлээс зайлсхийх хүрээнд АНУ, Их Британи, Австрали улс дахь корреспондент банкны харилцаа хумигдахад хүрсэн. Олон улсын корреспондент банкны харилцааны хувьд зохицуулалтын арга хэмжээтэй уялдуулан корреспондент банкууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсаар байна.




Дэлхийн банкны судалгаанд олон улсын корреспондент банкны харилцааг цуцлахад нөлөөлсөн хэд хэдэн голлох шалтгаануудыг дурдсан байна (World Bank, 2015). Судалгаанд оролцогчдын дийлэнх нь корреспондент банкны харилцаатай байх нь ашиггүй учир корреспондент банкны харилцаагаа цуцалж байна гэжээ. Удаагаар нь ерөнхий эрсдэл өндөр, хууль эрх зүй, зохицуулалт болон хяналт шалгалтын өөрчлөлтүүд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй зэрэг шалтгаанууд корреспондент банкны харилцааг бууруулахад нөлөөлсөн байна.

Корреспондент банкны харилцаанд гарч буй чиг хандлага

- Ностро дансны бууралт:

Ностро данс гэдэг ойлголт нь энгийнээр гадаадын банканд нээсэн дотоодын банкны данс юм. Корреспондент банкны харилцаанд ностро дансыг ашиглаж гадаад валютын арилжааны төлбөр тооцоог хийдэг. Олон улсын корреспондент банкны харилцаанд ажиглагдаж байгаа бас нэг томоохон чиг хандлага бол Ностро дансны бууралт юм. Уг хандлагад Латин Америк, Карибын тэнгисийн орнууд хамгийн их хямралд өртсөн байна.

- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өртгийн өсөлт:



дүнгийн 4.49%), Африкийн Сахарын цөлөөс урагш бүс нутаг мөнгө хүлээн авах үед хамгийн өртөг өндөр (8.27%) байжээ. Улмаар банк нь мөнгөн гуйвуулгын зардлын хувьд хамгийн өндөр өртөгтэй (10.40%) үйлчилгээ үзүүлэгч болсон байна.

Иймд өнөөгийн корреспондент банкны харилцааны чиг хандлага нь зардал өсөх, зохицуулалтын шаардлагууд улам бүр нэмэгдэх болсон, мөн хүлээгдэж буй эрсдэл өндөр байгаа нь корреспондент үйл ажиллагааны ашгийн хэмжээг бууруулж, улмаар корреспондент банкны харилцааг сайжруулах боломжийг хязгаарлан, тааламжгүй нөхцөлийг бүрдүүлж байна. Ялангуяа эдийн засгийн цар хүрээ энэ төрлийн бизнест ихээхэн нөлөөлдөг бөгөөд зарим банкууд ашиг орлогоороо комплаенсийн зардлаа нөхөхөд хүндрэлтэй болоод байна. Улмаар энэ төрлийн бизнес нь “бага эрсдэл - бага ашиг” бизнесийн төрлөөс “өндөр эрсдэл - бага ашиг” төрөлд шилжих хандлагатай байна.

Монгол Улс

Монгол Улс 2019 онд ФАТФ-ын “Саарал жагсаалт”-д орсноор олон улс орнууд манай улстай хийгдэх корреспондент банкны үйл ажиллагааг эрсдэлтэй гэж дүгнэн эрсдэлээс зайлсхийх арга хэмжээг авах нөхцөл бүрдсэн юм. Улмаар ФАТФ-ын техник хэрэгжилтийн хүрээнд өгсөн үүрэг даалгавруудыг хэрэгжүүлж, шаардлагатай арга хэмжээнүүдийг авсны үр дүнд 2020 онд “Саарал жагсаалт”-аас гарсан. Харин уг жагсаалтад орсноос үүдэн гарсан бодит үр дүн болох олон улсын корреспондент банкны харилцаа сайжраагүй байдалтай байна. Санхүүгийн мэдээллийн албанаас олон улсын сайн туршлагыг харгалзан үзэж, манай улсын корреспондент банкны харилцаа одоогийн байдлаар өөрчлөлтгүй зогсчихоод байгаа шалтгаан ба цаашид уг харилцааг хэрхэн бэхжүүлэх боломжийг тодорхойлох зорилгоор судалгааны ажил хийж байна. Тус судалгааны ажлын хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх арилжааны банкуудаас авах корреспондент банкны харилцааны талаарх асуулгын маягтыг боловсруулсан. Тодруулбал, Ностро дансны мэдээллийг авч хэрхэн өөрчлөгдөж буйг тодорхойлсон. Үүний үр дүнгээс корреспондент банкны харилцааг сэргээх чиглэлээр ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах шаардлагатай байна.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ФАТФ-ЫН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН БОЛОН
ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЦАГ ХУГАЦААНЫ МАТРИЦ (2007-2021)

С	Бүрэн биелүүлсэн
LC	Дийлэнхийг биелүүлсэн
PC	Хэсэгчлэн биелүүлсэн
NC	Биелүүлээгүй
NA	Үнэлээгүй

Хуучин	ЗӨВЛӨМЖ	40+9									40+11					
		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
	Тайлангийн төрөл	Харицан үнэлгээгүй тайлан					Ахицын тайлан		5 дахь явцын тайлан			Харицан үнэлгээгүй тайлан		2 дахь явцын тайлан	3 дахь явцын тайлан	4 дахь явцын тайлан
-	1	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	PC	PC	PC	PC	LC
31	2	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC	LC
1&2	3	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC
3	4	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC

II	Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг	5	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC
III	Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилгот санхүүгийн хориг арга хэмжээ	6	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	PC	PC	LC	LC	LC
-	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилгот хориг арга хэмжээ	7	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NC	NC	LC	LC	LC
VIII	Ашгийн бус байгууллага	8	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC
4	Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж	9	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC
5	Харилцаагийг таньж мэдэх	10	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC
10	Баримт материал хадаглах	11	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	C	C	C	C	C
6	Улс төрд нөлөө бүхий этгээд	12	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC
7	Корреспондент банкны үйл ажиллагаа	13	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC
VI	Мөнгө, үнэ цэн бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ	14	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	PC	PC	PC	C

8	15	Шинэ технологи	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC
VII	16	Цахим шилжүүлэг	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC
9	17	Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC
15&22	18	Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC
21	19	Өндөр эрсдэлтэй улс орнууд	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC
13&IV	20	Сэжигтэй гүйлгээг мэдээлэх	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC
14	21	Мэдээллийг задруулах болон нууцлал	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	C
12	22	СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC
16	23	СББМҮҮ: Бусад арга хэмжээ	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC
33	24	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC
34	25	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC
23	26	Санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалт	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC

29	Хянан шалгагчийн эрх мэдэл	27	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC	LC	LC
24	СББМҮҮ-ийн зохицуулалт, хянан шалгалт	28	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	LC	LC
26	Санхүүгийн мэдээллийн алба	29	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	PC	C	C
27	Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг	30	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	C	C	C	C
28	Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл	31	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C
IX	Бэлэн мөнгө зөөвөрлөгчид	32	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC
32	Статистик мэдээлэл	33	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	PC	LC	LC
25	Зааварчилгаа, эргэх холбоо	34	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	PC	LC	LC
17	Шийтгэлийн арга хэмжээ	35	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC
35&I	Олон улсын арга хэрэгслүүд	36	PC+NC	PC+NC	PC+NC	PC+NC	NC	NC	LC	LC	LC	C	C	C	C
36&V	Эрх зүйн харилцан туслалцаа	37	LC+PC	LC+PC	LC+PC	LC+PC	LC+PC	PC	PC	LC	LC	C	C	C	C
38	Эрх зүйн харилцан туслалцаа: хөрөнгө царцаах, хураах	38	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC
39	Гэмт хэрэгтэн шилжүүлэх	39	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC
40	Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр	40	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC	LC	LC